

2022



**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ,
ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН**

МЭДЭГДЭЛ

Энэхүү мэдэгдэл нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн гаргасан Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ) тайлангийн хамрах хүрээ, хязгаарлалтыг тодруулах зорилготой юм. БОНЗ-ын тайлан нь байгаль орчны тогтвортой байдал, нийгмийн хариуцлага, компанийн засаглалын үйл ажиллагаатай холбоотой тус байгууллагын хүчин чармайлт, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг агуулах боловч дараах зүйлсийг ойлгох нь чухал юм.

1. Тайлангийн ерөнхий шинж чанар: Тус тайлан нь зөвхөн мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн бөгөөд санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын зөвлөгөө биш юм.
2. Мэдээллийн үнэн зөв байдал: Тус тайлан нь хамгийн сүүлийн үеийн, үнэн зөв мэдээллүүдийг агуулахыг зорьж байгаа ч энэ нь тодорхой таамаглал, тооцоолол, төсөөлөл, хэтийн төлөвийг агуулсан байж болно.
3. Хязгаарлагдмал хамрах хүрээ: Тус тайлан нь тодорхой БОНЗ-ын холбогдолтой үйл ажиллагаа дээр төвлөрсөн тул байгууллагын бүхий л үйл ажиллагааг тус тайлангаар дүгнэх боломжгүй болно.
4. Гадаад хүчин зүйлс: Байгууллагын БОНЗ-ын гүйцэтгэлд зохицуулалтын өөрчлөлт, зах зээлийн нөхцөл байдал, дэлхийн үйл явдлууд зэрэг олон гадаад хүчин зүйлс нөлөөлөх боломжтой ба тус тайлан нь эдгээр хүчин зүйлсийн БОНЗ-ын гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг бүрэн судалж тусгаагүй байх боломжтой юм.
5. Ирээдүйн гүйцэтгэл: Тус БОНЗ-ын тайланд байгууллагын ирээдүйн БОНЗ-ын зорилго, зорилт, эрмэлзлийн талаар агуулж болох ба эдгээр нь ирээдүйн БОНЗ-ын гүйцэтгэл, үр дүнгийн баталгаа биш болно.
6. Хэрэглээ ба хариуцлага: Бид БОНЗ-ын тайлангийн үнэн зөв байдлыг хангахын тулд хүчин чармайлт гарган ажиллаж байгаа хэдий ч тайлантай холбогдох аливаа алдаа, орхигдол, үл нийцэлтэй тооцоолол болон түүний агуулгад үндэслэн хийсэн аливаа үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээхгүй болно.

Тус БОНЗ-ын тайлантай танилцах эсхүл ашигласнаар та энэхүү мэдэгдэлд дурдсан нөхцөл, хязгаарлалтыг хүлээн зөвшөөрч байгаа болно. Хэрэв та энэхүү мэдэгдлийн аль нэг хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол тайланг ашиглахаас татгалзана уу.

Байгууллагын БОНЗ-ын үйл ажиллагаа болон энэхүү мэдэгдлийн талаар нэмэлт мэдээлэл, тодруулга авахыг хүсвэл info@cumongol.mn болон bolortuya.b@cumongol.mn хаягаар холбогдоно уу

Бүлэг

1

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Удирдлагын үүрэг амлалт
Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги
Удирдлага, бүтэц зохион байгуулалт
Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ
Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа
Хяналт
Тайлагнал ба баталгаажуулалт
Гишүүнчлэл, хамтын ажиллагаа

Бүлэг

2

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
Эрчим хүч
Хүлэмжийн хийн ялгарал
Уур амьсгалын эрсдэл
Ус
Хог хаягдал
Биологийн олон янз байдал

Бүлэг

3

НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ

Хүний нөөцийн хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Эрх тэгш байдал
Хүртээмжтэй байдал
Нийгмийн хариуцлага, ил тод байдал
Тогтвортой өртгийн сүлжээний менежмент

Бүлэг

4

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

Компанийн засаглал
Авилга ба ёс зүй
Комплајнс

Бүлэг

5

САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Хөдөө аж ахуй ба хүнсний үйлдвэрлэл
Боловсруулах үйлдвэрлэл



МЭНДЧИЛГЭЭ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ажилчид болон удирдлагын багийг төлөөлөн 2022 оны Байгаль орчин нийгэм засаглал (БОНЗ)-ын тайланг танилцуулж байгаадаа баяртай байна.

СU компанийн бизнесийн стратегийн төвд "Хамтын үнэ цэн"-ийн ойлголт хамгийн чухал юм. Энэхүү хамтын үнэ цэн нь бидний бүхий л үйлдэл, шийдвэр гаргалтад нөлөөлдөг суурь зарчим билээ. Бид уг алсын хараанд хөтлөгдсөөр 2022 онд бизнесийн хүрээгээ хурдтай тэлж, илүү олон ажлын байрыг бий болгон, нийлүүлэгчдийнхээ бизнесийг өргөжихөд туслаж, Улаанбаатар хотын иргэдэд эрүүл, аюулгүй, чанартай хоол хүнс, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүллээ.



**ҮРГЭЛЖ
ДЭМЖДЭГ ТА
БҮХЭНДЭЭ ЧИН
СЭТГЭЛЭЭСЭЭ
ТАЛАРХАЖ
БАЙНА**

“Хамтын үнэ цэн”-ийн хүрээнд бид шударга, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаагаа явуулахыг эрмээлэн компанийн засаглалаа сайжруулсаар байна. Бид хүмүүс, процесс, тогтолцоондоо хөрөнгө оруулж байгууллагын түвшинд ёс зүйг баримтлан ажилласаар байна. Мөн нийгэмдээ хариуцлагатай компани байх нь бидний нэн тэргүүний зорилго юм. 2022 оны онцлох үйл явдлаас дурдвал хоол үйлдвэрлэлийн төвд НАССР (Hazard Analysis Critical Control Point) удирдлагын системийг нэвтрүүлсэн явдал байлаа. Мөн үүнтэй эн тэнцэхүйц арга хэмжээг хэрэгжүүлсэн нь бид бэлтгэн нийлүүлэгчиддээ хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоо, ёс зүйг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулсан явдал юм. 2022 онд СУ конвененс сүлжээ дэлгүүрүүд нь шинэ шийдэл, ая тухтай, чанартай үйлчилгээний ахисан стандартыг зах зээлд нэвтрүүлсээр дараагийн жилтэйгээ золгож байна.

Бидний зорилго бол маш энгийн. Монголын хотжиж буй иргэдийн амьдралын чанарыг сайжруулах юм.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд бид харилцагч, бэлтгэн нийлүүлэгч, ажилчидтайгаа харилцаагаа илүү бэхжүүлж, тогтвортой ирээдүйн төлөөх олон алхмуудыг хийж чадсан. Үүндээ тулгуурлан бид Байгаль орчин, Нийгэм, Засаглал гэх тодотголтойгоор компанийн хөгжилд шинэ хуудсыг эхлүүлэхэд бэлэн боллоо. Бид илүү олон зүйлд хүрч чадна гэдгээ мэдэж байгаа, тэдгээрийг хийж чадна гэдэгтээ ч итгэл дүүрэн байна.

Манай компанийн 2022 оны БОНЗ тайлан нь компанийн хувьд бид хэн болох, бидний байр суурийн талаар товч мэдээллийг өгөх болно. Бидний үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин, нийгмийн сайн сайхан байдалд хэр их нөлөө үзүүлэх боломжтойг бид бүрэн ойлгож, ухамсарлаж байгаа. Иймээс бид өөрсдийн үүрэг хариуцлагыг чухалчлан үзэж, оролцогч талууддаа урт хугацааны үнэ цэнийг хүргэхийн төлөө тууштай ажиллаж байна.

Цаашид бид эрсдэлийн удирдлагын хариуцлагатай туршлагаа үргэлжлүүлж, бизнес хийхэд хамгийн үр ашигтай шийдлийг хайж, үйл ажиллагаандаа тогтвортой, нүүрстөрөгчийн ялгаралт багатай туршлагыг хэрэгжүүлэхээр хүмүүс болон үйл ажиллагаандаа хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөж байна. Бид эх дэлхий, нийгэмдээ эерэг өөрчлөлтийг авчрахаа амлаж байна.

Та бүхнийг тогтвортой хөгжлийн төлөөх бидний хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд нэгдэхийг уриалж байгаадаа таатай байна. Бид хамтдаа байгаль орчин, нийгэмд эерэг нөлөө үзүүлж, “Хамтын үнэ цэн”- ээ нэмэгдүүлж чадна.

Гари Стивен Биондо

Төлөөлөн удирдах зөвлөлийн БОНЗ хорооны захирал

ТАНИЛЦУУЛГА

Уг Байгаль орчин, нийгэм, засаглал (цаашид БОНЗ гэх)-ын тайланг Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн захиалгаар “Антифражайл” ХХК нь 2023 оны 3 сарын 12-ноос 2023 оны 4 сарын 11-ний өдрийн хугацаанд боловсруулж, хөндлөнгийн үнэлгээ, зөвлөмжийн хамт хийж гүйцэтгэлээ. Компани нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохын хувьд өөрийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэм, засаглалд үзүүлэх нөлөөллийг Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын дагуу ийнхүү хоёр дахь жилдээ сайн дурын үндсэн дээр нийт хувьцаа эзэмшигчид, харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд олон нийтэд нээлттэй тайлагнаж байна.

Тайланг бэлтгэхдээ Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), МУ дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), МУ дахь НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газар, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Тогтвортой байдлын төлөөх санхүүгийн төвүүдийн олон улсын сүлжээний хамтран боловсруулсан “Байгаль орчин, нийгэм, засаглал ба тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийн дагуу болон бусад олон улсын тогтвортой байдлын тайлагналын удирдамжуудыг ашиглан холбогдох дата мэдээллийг цуглуулж, шинжилж, баталгаажуулж, холбогдох зөвлөмжөөр хангасан болно.

Энэхүү БОНЗ ба тогтвортой байдлын тайлан нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК, түүний охин компаниуд болох Сэнтрал Фүүдс ХХК, Сэнтрал Коммерс ХХК-ийн 2022 оны үйл ажиллагааг хамарсан бөгөөд шаардлагатай хэсгүүдэд түүхэн дата мэдээллийг оруулсан.

БОНЗ ба тогтвортой байдлын тайлангийн хүрээнд дараах асуудлуудын хүрээнд мэдээлэл боловсруулалт хийж уг тайланд оруулав.

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТЛОЦОО

- MS1 Удирдлагын менежмент, амлалт
- MS2 Тогтвортой байдлын бодлого зохицуулалт
- MS3 Удирдлагын бүтэц
- MS4 Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ
- MS5 Чадавч бүрдүүлэлт
- MS6 Хяналт шинжилгээ
- MS7 Тогтвортой байдлын тайлагнал, баталгаажуулалт
- MS8 Гишүүнчлэл

БАЙГАЛЬ ОРЧИН

- E1 Эрчим хүч
- E2 Хүлэмжийн хийн ялгарал
- E3 Уур амьсгалын өөрчлөлт
- E4 Ус
- E5 Хог хаягдал
- E6 Биологийн олон янз байдал

Зөвлөх багийн зүгээс компани нь ийнхүү ОУ-ын жишигт нийцсэн БОНЗ, тогтвортой байдлын тайланг боловсруулж, оролцогч талуудад нээлттэй мэдээлж буйг сайшаахын зэрэгцээ энэ туршлага нь цаашид улам олон Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг сайн засаглал, тогтвортой байдлын арга туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд үлгэрлэл болж, МУ-ын тогтвортой хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа, мөн худалдаа, хүнс үйлдвэрлэлийн салбарт урт хугацааны үнэ цэнийг бий болгоход хувь нэмрээ оруулж байна хэмээн үзэж байна. Цаашлаад БОНЗ, тогтвортой байдлын тайланг жилээс жилд тогтмол баяжуулан олон нийтэд тайлагнаж танилцуулах, БОНЗ-ын илэрсэн үл тохирлуудыг жил ирэх тусам засч сайжруулснаар салбараа манлайлахаас гадна дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, шууд ба шууд бус үр өгөөж, үнэ цэнийг нийгэмд бий болгох, нэр хүндээ өсгөх боломжоор дүүрэн байгааг дурдах нь зүйтэй.

Тайлангийн уншигчдад болон компанийн оролцогч талуудад уг тайлантай холбоотой нэмэлт тодруулга байвал БОНЗ ба тогтвортой байдлын тайланг боловсруулсан үнэлгээний багтай дараах хаягаар холбогдох боломжтой.

М.Оюунгэрэл, oyungerel@airee.mn

Э.Нандин-Эрдэнэ, nandinerdene.enkhtuvshin@gmail.com

НИЙГЭМ

- S1 Хүний нөөцийн хөгжил
- S2 Хөдөлмөрийн аюулгүй байдал
- S3 Эрх тэгш байдал
- S4 Хүртээмжтэй тэгш оролцоо
- S5 Нийгмийн хариуцлага, ил тод байдал
- S6 Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага

САЛБАРЫН НЭМЭЛТ ҮЗҮҮЛЭЛТ

- AF1 Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл
- MA1 Боловсруулах үйлдвэрлэл


ЗАСАГЛАЛ

- G1 Компанийн засаглал
- G2 Авилга, ёс зүй
- G3 Комплайнс, хууль дүрмийн мөрдөлт
- G4 Оролцогч талуудын оролцоо

АРГАЧЛАЛ

Мэдээлэл цуглуулах, баталагаажуулалт

БОНЗ-ын тайланг боловсруулахдаа дараах мэдээллийн эх үүсвэрүүдийг ашигласан.



Газар дээрх үзлэг

10 салбар дэлгүүр
Хүнсний үйлдвэр, хүйтэн хэлхээ
Түгээлтийн төв

Оролцогч, холбогдох талуудаас авсан асуумж

ТУЗ-ийн гишүүд, Удирдлагын багийн гишүүд, хувьцаа эзэмшигчид, оффисын, сүлжээ дэлгүүрийн болон бусад ажилтнууд, ханган нийлүүлэгчид, хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд, үйлчлүүлэгчид

Онлайн дью дилиженс

Цахим орчинд байрлуулсан мэдээлэл, харилцагчид, талуудын гомдол санал

Мэдээллийг “Байгаль орчин, нийгэм, засаглал ба тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийн дагуу болон Олон улсын тайлагналын санаачилга (GRI)-д дурдсан аргачлалыг лавлагаа болгож, бэлэн тайлагнах боломжтой өгөгдөл мэдээллийн хүрээнд боловсрууллаа. Мөн БОНЗ-ын тайланг боловсруулахад ашигласан, мөн цуглуулах, тайлагнах боломжгүй (n/a тэмдэглэгээтэй) өгөгдөл, мэдээллийг тухай бүрт нь ишлэн бичсэнийг цаашид анхааран бүртгэж, тайлагнадаг болох нь зүйтэй.

Мэдээлэл боловсруулалт

Хүлэмжийн хийн тооцооллыг Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Засгийн газар хоорондын мэргэжилтний хороо (IPCC)-ны боловсруулсан, 2006 оноос хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үндэсний хүлэмжийн хийн тооллогын аргачлал, түүнд хамаарах стандарт хүлэмжийн хийн ялгарлын коэффициентүүдийг ашиглан тооцоолсон. Монгол Улсын төвлөрсөн цахилгаан шугам, системтэй холбоотой тус коэффициентийг Японы Хамтарсан Кредит олгох механизмийн тооцооллоор буюу 1 кВт.ц үйлдвэрлэхэд 797 гCO_{2e} ялгаруулдаг гэсэн коэффициентийг ашиглан тооцсон болно.



ХУРААНГУЙ

1	Огноо (он, сар, өдөр):	2023 оны 04 сарын 11
2	Үнэт цаас гаргагчийн нэр:	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК
3	Үнэт цаас гаргагчийн код (МХБ симбол):	CUMN
4	Салбар/үйлдвэрлэл (МХБ-ийн салбарын ангилал):	Худалдаа
5	Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК, Сэнтрал Фүүдс ХХК, Сэнтрал Коммерс ХХК
6	Тайлангийн хамрах хугацаа:	2022 оны 1 сарын 1 – 2022 оны 12 сарын 31
7	Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас	Ч.Номинзул, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Санхүүгийн шинжээч Nominzul.ch@cumongol.mn
8	Тайланг баталгаажуулсан Гүйцэтгэх захирал, ТУЗ-ын даргын мэдээлэл (нэр, албан тушаал):	ТУЗ-ын хараат бус гишүүн, ТУЗ-ын дэргэдэх БОНЗ-ын хорооны гишүүн Гари Биондо Gary.b@cumongol.mn

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Сэнтрал Экспресс Үзүүлэлт, хэмжих нэгж	Сэнтрал Фүүдс Үзүүлэлт, хэмжих нэгж
MS	Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны шалгуур үзүүлэлтүүд				
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/ мэдэгдэл байдаг эсэх	Үгүй	
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Үгүй	
MS2.2		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Үгүй	
MS3.1		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм	

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Сэнтрал Экспресс Үзүүлэлт, хэмжих нэгж	Сэнтрал Фүүдс Үзүүлэлт, хэмжих нэгж
MS3.2		Бүтэц удирдлага	ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм	
MS3.3		Бүтэц удирдлага	Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх	Үгүй	
MS3.4		Бүтэц удирдлага	Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Үгүй	
MS3.5		Бүтэц удирдлага	Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тогтмол тусгадаг уу?	Тийм	
MS4.1		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн процесс, үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Үгүй	
MS5.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	0	Тогтвортой хөгжлийн сургалтын цаг байхгүй. Нийт сургалтын тоо 30.6цаг
MS6.1		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Үгүй	Үгүй
MS7.1		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм	
MS7.2		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?	Үгүй	
MS7.3		Тогтвортой байдлын тайлагнал	Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?	Тийм	Үгүй

				Сэнтрал Экспресс	Сэнтрал Фүүдс
Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
MS8.1		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? Үүнд, хүний эрх болон бизнесийн тунхаглал орно.	Үгүй	
E	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд				
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	133,972,214 кВт.ц	E1.1
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	13,044,404 кВт.ц	E1.2
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	435,337 гДж	E1.3
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр). Үүнд,	14 тн нүүрс 299,955.6л дизель 66,450л газ	
			1. Халаах зорилгоор хэрэглэсэн түлш буюу нүүрс, хий	14 тн нүүрс 66,450л газ	
			2. Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	299,955.6л дизель	
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	100%	100%
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%	0%
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	109.253.9тн CO2e	
E2.2		Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	Тайлагнах боломжгүй (n/a)	

				Сэнтрал Экспресс	Сэнтрал Фүүдс
Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
E2.3		Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт)бууралт	Байхгүй	Байхгүй
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Үгүй	Үгүй
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Үгүй	Үгүй
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	Байхгүй	Байхгүй
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	Байхгүй	Байхгүй
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?	Үгүй	Үгүй
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	31'467 м3	31'992 м3
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	Байхгүй	саарал ус ашигладаггүй
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	0%	0%
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	0%	0%
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	Тайлагнах боломжгүй (n/a)	
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	Тайлагнах боломжгүй (n/a)	
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	100кг	
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	Тайлагнах боломжгүй (n/a)	13.60%

				Сэнтрал Экспресс	Сэнтрал Фүүдс
Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	Байхгүй	0
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэн өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зөргөлдөөх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	Байхгүй	0%
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд				
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	70%	72%
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	1,912	27
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	62	30.6
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	0%	0%
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	5 цаг	97.2
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	3000 хүн	Эрүүл мэндийн хугацаат үзлэг 80, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 391, хеликобактерийн тест 68, дүүргийн эрт илрүүлгийн шинжилгээ 24
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй	үгүй
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм

				Сэнтрал Экспресс	Сэнтрал Фүүдс
Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Тийм
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эр-34% Эм-66%	Эр-20%, Эмэгтэй 80%
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-100%	n/a
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-27% Эм-73%	Эр-75%, Эм-25%
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-37% Эм-63%	Эр-39%, Эм-61%
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	Эмэгтэй/ Эрэгтэй=1.14	Эмэгтэй/ Эрэгтэй=1.22
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм	Үгүй
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	4 %	4 %
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Үгүй	Үгүй
S4.4		Торгууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ	0	0
S5.1	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	Үгүй	
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	Байхгүй	Байхгүй
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/ журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм	

				Сэнтрал Экспресс	Сэнтрал Фүүдс
Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм	
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100%	Оролцогч бүх талуудаас ирсэн санал гомдлыг 100% шийдвэрлэж, залруулах арга хэмжээ авч ажиллаж байна.
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-оор ангилсан	Энэ чиглэлд оруулсан хөрөнгө оруулалтыг ангилан харсан тоо баримт бэлэн байхгүй байна.	
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Хүүхдийн хүнд хөдөлмөр эрхлэхгүй, байгаль орчинд ээлтэй бодлого баримтлана гэж Гэрээний стандарт нөхцөлд заасан.	
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	91 %	90%
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	Байхгүй	
G	Засаглалын шалгуур үзүүлэлтүүд				
G1.1	Компанийн засаглал	Компанийн засаглалын бодлого, журам	Шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?	Тийм	
G1.2		Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	1/3	
G1.3		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	Тийм	

				Сэнтрал Экспресс	Сэнтрал Фүүдс
Код	Ангилал	Шалгуур үзүүлэлтүүд	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт, хэмжих нэгж
G2.1	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм	
G3.1	Комплайнс	Комплайнсын бодлого	Комплайнсын бодлого, журам бий юу?	Тийм	
G3.2		Комплайнсын хөтөлбөр	Комплайнсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	Батлуулах гэж байгаа	
Салбарын онцлогтой нэмэлт шалгуур үзүүлэлтүүд (зөвхөн өөрийн компанид хамаарах салбарын асуултад хариулна)					
AF1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?	Байхгүй	Байхгүй
AF2		Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь	0	0
AF3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	0.035% буюу 103'609'484 төг	байхгүй
MA1	Боловсруулах	Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам	Тийм	Тийм
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь	0%	
MA3		Ногоон шошго, гэрчилгээжүүлэлт	Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь	Тайлагнах боломжгүй (n/a)	0%

Бүлэг

1

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Удирдлагын үүрэг амлалт

Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги

Удирдлага, бүтэц зохион байгуулалт

Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ

Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа

Хяналт

Тайлагнал ба баталгаажуулалт

Гишүүнчлэл, хамтын ажиллагаа



УДИРДЛАГЫН ҮҮРЭГ АМЛАЛТ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн удирдлагын зүгээс тогтвортой хөгжлийн чиглэлд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, баримтлах зарчмын талаар гаргасан, баталсан үүрэг амлалтын шинжтэй мэдэгдэл одоогоор байхгүй байна.




САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Цаашдын өсөн нэмэгдэж буй дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын санаачилга, чиг хандлага, түүнчлэн шинэ зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлд өгч буй анхаарал зэргийг үндэслэн байгууллагын цаашдын бодлого, стратегид тогтвортой хөгжлийн асуудлуудыг үндсэн асуудлуудын нэгээр тодорхойлж, холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулж, удирдлагын түвшинд манлайлал үзүүлэн ажиллах.

Хамгийн ойрын суралцаж болох жишээ нь:

- “Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХК-ийн үндсэн хувьцаа эзэмшигч болох БНСУ-ын БиЖиЭф Ритэйл Ко., Лтд (BGF Retail Co., Ltd.) компанийн “Байгаль орчны удирдлагын стратеги”-ийг өөрийн үйл ажиллагаанд тохируулан хэрэгжүүлэх
- БиЖиЭф Ритэйл Ко., Лтд компанийн адил өөрсдийн байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг оролцоонд суурилсан аргаар тодорхойлж, компанийн дунд ба урт хугацааны бодлогод эдгээр асуудлуудыг тусган НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах
- Тогтвортой хөгжлийн хүрээ (framework)-г боловсруулах, компанийн нийт ажилтнуудад уг бодлогын ач холбогдол, цар хүрээ зэргийг таниулах, цаашлаад нийт хувьцаа эзэмшигчид, ханган нийлүүлэгчид, бусад хамтрагч байгууллагууд, харилцагч нарт нээлттэй мэдээллэх

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИ



САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

- БиЖиЭф Ритэйл Ко., Лтд компанийн адил өөрсдийн байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг оролцоонд суурилсан аргаар тодорхойлж, компанийн дунд ба урт хугацааны бодлогод эдгээр асуудлуудыг тусган НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах

- Тогтвортой хөгжлийн хөтөлбөр (framework)-г боловсруулах, компанийн нийт ажилтнуудад уг бодлогын ач холбогдол, цар хүрээ зэргийг таниулах, цаашлаад нийт хувьцаа эзэмшигчид, ханган нийлүүлэгчид, бусад хамтрагч байгууллагууд, харилцагч нарт нээлттэй мэдээллэх

УДИРДЛАГА, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх

ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх



“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02-р сарын 25-ны өдрийн 7 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх “Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо”-ны үйл ажиллагааны журмыг баталсан бөгөөд Хороо нь дараах бүрэлдэхүүнтэй.

ТУЗ-ийн хорооны нэр	Гишүүдийн нэр	Албан тушаал	Томилогдсон огноо
Байгаль орчин, нийгэм засаглалын хороо	Гари Биондо	Хороон дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн	12/28/2021
	О.Батмөнх	ТУЗ-ийн ердийн гишүүн	10/31/2019
	Б.Бат-Эрдэнэ	ТУЗ-ийн ердийн гишүүн	12/28/2021



Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх

Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/ хавсран) байдаг эсэх



Хороо нь компанийн засаглалын ОУ-ын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, КомпанийнБОНЗ-тай холбоотой бодлого, стратеги болон дүрэм журмыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хянан нягтлах үүрэгтэй.

ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

Хорооноос гаргаж буй саналууд нь зөвхөн зөвлөмж хэлбэртэй байх бөгөөд түүнийг ТУЗ заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

Хороо нь компанийнэрх бүхий албан тушаалтан, ажиллагсдаас баримт бичиг гаргуулан авах, тэдгээрийг хуралдаа ажиглагчаар оролцуулах эрхтэй

Хороо нь гадны зөвлөх, эксперт болон зөвлөх үйлчилгээг авах эрхтэй

Хороо нь үйл ажиллагааны талаар ТУЗ-д тогтмол хугацаанд тайлагнах ба жилд 2-оос доошгүй удаа тайлагнах бөгөөд шаардлагатай тохиолдолд хуралдаан бүрийн дараа ТУЗ-д илтгэнэ.

БОНЗ-ын хүрээнд Компанийнүйл ажиллагаа болон чухал оролцогч талуудын эрх ашигт чухал нөлөө үзүүлэх асуудлуудыг тодорхойлох

КомпанийнБОНЗ-ын зорилт, стратеги, хамрах хүрээ, дүрэм журмыг боловсруулах, хянах, ТУЗ-д холбогдох саналыг хүргүүлэх, ТУЗ-өөс баталсан БОНЗ-ын дүрэм, журмыг хэрэгжүүлэх

ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйлдвэрлэлийн аюулгүй байдал, байгаль орчны хамгаалалт, нийгмийн хариуцлагын удирдлага болон компанийнзасаглалтай холбоотой Компанийндүрэм журмыг боловсруулах, шинэчлэх

Компанийнхүний эрх, бизнесийн ёс зүй, шударга байдал, олон талт байдлын тухай журмууд болон БОНЗ-тай холбоотой асуудлуудыг холбогдох гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдэд судалгаа хийх замаар бизнесийн загварт нэгтгэх, журмуудыг хянаж судлах

БОНЗ-ын төлөвлөгөөг боловсруулах, гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэлийг сайжруулах, үйл ажиллагааны зөвлөж боловсруулах

Компанийнхөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн эрсдэлийн үнэлгээ хийж, хянах гэсэн ерөнхий үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Тогтвортой хөгжлийн бодлого, цар хүрээг тодорхойлсон бодлогын баримт бичиг батлагдсанаар бодлогод тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх, зөвлөмжөөр хангах, хянах, дата мэдээлэл цуглуулах, оролцогч талуудыг мэдээллээр хангах, тайлагнах зэрэг үйл ажиллагаа нь цаг, энерги, шинээр суралцах боломж ба нөхцлийг шаарддаг учраас цаашид тогтвортой хөгжил, БОНЗ хариуцсан бүтэн цагийн албан тушаал, ажлын байрыг шинээр үүсгэн, хариуцсан ажилтантай болох

Компанид тогтвортой хөгжил, БОНЗ-ын асуудлыг үйл ажиллагааны нэг хэсэг мэт төлөвшүүлэхэд удирдлагын манлайлал чухал нөлөөлөл үзүүлдэг тул цаашид удирдлагын багийн түвшинд тогтвортой хөгжлийн асуудал эрхэлсэн удирдлагын албан тушаалыг шинээр бий болгож байгууллагын манлайлал, үүрэг амлалтыг оролцогч талуудад харуулах.



Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тогтмол тусгадаг уу?

ТУЗ-ийн дэргэдэх “БОНЗ-ын хороо”-ны үйл ажиллагааны чиглэл, эрх үүргийн дагуу БОНЗ-ын чиглэлд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар ТУЗ-д жилд 2-оос доошгүй удаа тайлагнах үүрэг хүлээдэг. 2022 оны хувьд нийт 7 удаагийн ТУЗ-ийн хурал зохион байгуулагдаж, 37 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

ТУЗ-ийн үйл ажиллагаа	нэгж	2020	2021	2022
ТУЗ-ийн хурал зохион байгуулагдсан тоо	удаа	3	5	7
Хэлэлцсэн асуудлын тоо	тоо	10	24	37
Гүйцэтгэх захирлын хуралд оролцсон байдал	%	100%	100%	100%
ТУЗ-н хараат бус гишүүний хуралд оролцсон байдал	%	n/a	100%	100%

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ



Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн процесс, үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх

“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХК-ийн 2022 оны БОНЗ-ын тайланг бэлтгэх явцад байгууллагын нөлөөллийн матрицийг ТУЗ-ийн гишүүд, Удирдлагын багийн гишүүд, хувьцаа эзэмшигчид, оффисын болон сүлжээ дэлгүүрийн ажилтнууд, “Central Foods LLC” болон “Central Commerce LLC”-н ажилтнууд, ханган нийлүүлэгчид, хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд, үйлчлүүлэгчид гэсэн оролцогч талуудаас авсан асуумж дээр үндэслэн боловсрууллаа.

Нөлөөллийн үнэлгээ (Materiality assessment)-г дараах үе шаттайгаар хийв.



БОНЗ, тогтвортой хөгжилтэй холбогдох бүхий л асуудлуудыг цуглуулж, жагсаав.



Үүнээс Компанид шууд болон шууд бус хамааралтай гэж үзсэн асуудлуудыг 13 асуудлыг сонгон авав.





Нэг талаас Компанийн ТУЗ, удирдлагын баг, төв оффисын ажилтнууд, нөгөө талаас Оролцогч талуудыг оролцуулан нийт 45 орчим хүнээс судалгаа авав.










Судалгааны хариултуудад үндэслэн Нөлөөллийн матрицийг боловсруулж, асуудлуудын чухлын эрэмбийг харьцуулав.

Нөлөөллийн үнэлгээний үр дүнд үндэслэн Компанийнхувьд чухал бөгөөд Оролцогч талуудын сонирхолд байгаа дараах 5 асуудлыг ач холбогдол, үр нөлөөгөөр ангилж, тэдгээр асуудлуудын өөрсдийн анхааралд авч үлдэх чиглэлд ямар ажлууд хийж байгаа тухай доорх хүснэгтэд тайлбарлав.

МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ



No	Гол асуудлууд	Ач холбогдол		Үр нөлөө			Хэрэгжүүлж буй арга хэмжээ	ТХЗ
		CU Mongol	Оролцогч талууд	Зардал	Үр өгөөж	Эрсдэл		
1	Хүнсний аюулгүй байдал	+	+	100%	50%	50%	<p>CU хоолны үйлдвэр нь CU конвинеенс дэлгүүрт савласан хоолыг нийлүүлдэг бөгөөд хүнсний аюулгүй байдлын олон улсын Аюулын дүн шинжилгээ ба Эгзэгтэй цэгийн хяналтын (Hazard Analysis Critical Control Point) болон Үйлдвэрлэлийн зохистой дадлын (Good Manufacturing Practice) тогтолцооны болзлыг хангасан Монголын анхны нэг чиглэлийн урсгалтай нийтийн хоолны үйлдвэр юм.</p> <p>Тус хоолны үйлдвэр нь өдөр бүр 20 орчим нэр төрлийн 27 мянган ширхэг хоолыг хүнсний хугацаа уртасгагч, тогтворжуулагч бодисгүйгээр үйлдвэрлэж байна. Тус үйлдвэрийн барилгын давуу тал нь хүнсний үйлдвэр болон хөргөх өрөөг зориулалтын EPS, полиуретан хавтангаар дугуй булан гарган хийсэн нь нян бактери үржихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн.</p>	
2	Хөдөлмөрийн аюулгүй эрүүл тохилог ажлын байр	+		50%	0%	100%	<p>Ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс бүх дэлгүүрүүдийг камераар тоноглож, харуул хамгаалалтын компанитай гэрээ байгуулсан. Дэлгүүрт аюултай нөхцөл үүсэхэд харуул хамгаалалтын ажилтан дуудах тусгай товч байрлуулсан. Үйлдвэр болон агуулахын ажилчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулсан. Ингэснээр ажлын байранд, эсвэл гэртээ харих, ажилдаа ирэх замд ямар нэг осолд орох, гэнэтийн халдлагад өртсөн тохиолдолд нөхөн олговор авах боломжийг бүрдүүлэн, ажилтны аюулгүй ажиллах нөхцөл боломжоор ханган ажиллаж байна.</p> <p>“Сэнтрал Экспресс Си Ви Эс” ХК нь шилдгийн шилдэг ажил олгогчийг шалгаруулах “GOOD WORKPLACE AWARDS 2022” арга хэмжээнээс “Good Workplace with Best Leadership in HR Policy” буюу “Хүний нөөцийн бодлогоороо манлайлагч шилдэг ажил олгогч” шагналыг хүртсэн.</p>	

No	Гол асуудлууд	Ач холбогдол		Үр нөлөө			Хэрэгжүүлж буй арга хэмжээ	ТХЗ
		CU Mongol	Оролцогч талууд	Зардал	Үр өгөөж	Эрсдэл		
3	Харилцагчийн сэтгэл ханамж	+	+	0%	100%	50%	<p>Цаг хэмнэх, нэг цэгийн үйлчилгээ: Сим карт авах болон онлайн худалдааны Stora box үйлчилгээнүүдийг шинээр нэвтрүүлж, дэлгүүртээ байрших АТМ-ийн тоог нэмэгдүүлснээс гадна 2022 онд 1,615 бүтээгдэхүүн шинээр нэвтрүүллээ.</p> <p>CU апп хэрэглэгчдийн тоо 2022 оны 12 сарын 31-ны байдлаар 598,448-д хүрсэн бөгөөд апп-аараа дамжуулан 50 хувь хүртэл хямдрал урамшуулал санал болгодог. Үүнд: - Check-in урамшуулал - Купон үйлчилгээ</p> <p>Нийт 285 салбар дэлгүүртэй болсноор Улаанбаатар хотын нийтэд нээлттэй ариун цэврийн өрөөний тоог нэмэгдүүлээд байна. Түүнчлэн харилцагчийг сэтгэл ханамжтай байх дараах нөхцөлийг бүрдүүлсэн. Үүнд: - Бүрэн тохижилттой, сууж хооллох, кофе уух боломжтой - Үнэгүй WiFi - Хамгийн ойр, хамгийн олон салбар - 24 цагийн турш нээлттэй</p>	
4	Хүний эрхийг дээдэлсэн ажлын байр	+		0%	100%	50%	<p>Нийт ажилтнуудын 65%-аас дээш хувийг оюутан залуус эзэлж байна. Оюутан залууст хичээлийнхээ хажуугаар байнгын тогтмол орлоготой, уян хатан цагийн хуваарийн дагуу өөрт ойр байршлаас ажиллах боломжийг олгодгоороо давуу талтай.</p> <p>Нийт 3,400 гаруй ажилтантай ба одоогийн байдлаар 140 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байна. "CU" нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тусгай ажлын зар гаргахгүй, энгийн ажлын зарын дагуу бүртгүүлэх эсвэл найзаа урих хөтөлбөрийн дагуу ажилд орох боломжийг бүрдүүлсэн.</p>	
5	Нийгэмд үнэ цэн бий болгож буй байдал		+	0%	100%	50%	<p>- Хамгийн хүртээмжтэй үйлчилгээ: Орон сууц, оффис, эмнэлэг, сургууль, автобусны буудал, нисэх буудал, автовокзал, шатахуун түгээх газар - Хог хаягдлын талаар олон нийтийн ойлголтыг үйлдлээр үлгэрлэж байна: Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хаягдал баттэрий цуглуулах, Хуванцар хаягдлын хэрэглээг бууруулах "Аягагүй кофе" хөтөлбөр, "Аягатай кофе" дахин боловсруулах боломжтой "Rainforest Alliance Certified" аяга - "CU чамд тусалъя" хүүхэд хамгааллын хөтөлбөр - Шөнийн цагаар 18 хувиас дээш спиртийн агууламжтай согтууруулах ундааг худалдаалахгүй - Дотоодын ЖДБ-үүдийг дэмжигч: 17 компанийн 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг салбар дэлгүүрүүдээрээ борлуулж байна.</p>	  

ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр

Компани нь худалдаа, үйлчилгээний стандартыг өндөр түвшинд хадгалах чиглэлд ихээхэн анхаардаг бөгөөд шинэ ажилтанд зориулсан байгууллагын соёлыг танилцуулах, үйлчилгээний соёлыг хэвшүүлэх, эрүүл ахуйн зөв дадалтай болгох, ажилтанд мэдлэг ур чадвар олгох зэрэг сургалтуудыг тогтмол ордог. 2022 оны байдлаар Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ажилтнуудад нийт 136,674 хүн цагийн сургалт орсон бөгөөд ажилтнуудын сургалт хөгжилд нийт 535.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Салбарын онцлогоос шалтгаалан ажилтны шилжилт хөдөлгөөн өндөр байдаг тул шинээр ажилд орсон ажилтанд байгууллагын соёлыг танилцуулах, ойлгуулах, үйлчилгээний соёлыг хэвшүүлэх, эрүүл ахуйн зөв дадалтай болгох, ажлын ур чадвар мэдлэг олгох зэрэг сургалтуудыг ордог хэдий ч одоогоор ажилтнуудын сургалтын агуулгад тогтвортой хөгжилтэй холбоотой сэдэв, агуулга байхгүй байна.

- Цаашид тогтвортой хөгжил, БОНЗ-ын бодлого, цар хүрээг тодорхойлж, ТУЗ-өөр батлуулсны дараа нийт ажилтнуудад танилцуулж, сургалтын үеэр тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, тэгш байдал, олон талт байдлын ач холбогдлыг таниулах нь эдгээр бодлого, журмын хэрэгжилт, гүйцэтгэлийг нэмэгдүүлнэ.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

- Шинэ ажилтны сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжил, БОНЗ-ын асуудлуудыг “заавал судлах” байдлаар оруулж занших.
- “Хэмжиж чадвал – Сайжруулж чадна” дүрмийг байнга санаж, цаашид бүх төрлийн дата мэдээллийг хүйсээр ангилж, бүртгэж, зохистой хадгалж, дүн шинжилгээ хийж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах систем бүрдүүлэх.

ХЯНАЛТ



Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?

ТУЗ-ийн дэргэдэх "БОНЗ-ын хороо" нь компанийн БОНЗ-тай холбоотой бодлого, стратеги болон дүрэм журмыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хянан нягтлах үүрэгтэй ажилладаг тул Аудитын хорооны чиг үүрэгт тогтвортой байдлын асуудал хамаардаггүй.

ТАЙЛАГНАЛ БА БАТАЛГААЖУУЛАЛТ



Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 2021 оноос эхлэн (олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохоосоо өмнө) БОНЗ-ын тайланг боловсруулж, хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж, олон нийтэд нээлттэй байршуулж байна.



Танай компани уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?

Одоогоор тогтвортой байдал, БОНЗ-ын тайлангийн хүрээнд уур амьсгалын эрсдэлийг ОУ-ын стандартын дагуу тайлагнадаг практик байхгүй байна.

- Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх. Ингэхдээ компанид шууд болон шууд бус байдлаар учирч болох уур амьсгалын эрсдэлүүдийг тодорхойлох, түүнийг сааруулах болон дасан зохицох стратегийг хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

- Зорилт тавихын өмнө одоогийн нүүрсхүчлийн давхар ислийн ялгаруулалт (CO₂)-ын суурь хэмжээг тооцож, тогтооно. Ингэхдээ өөрийн үйл ажиллагаанаас ялгарч буй CO₂ ялгарлыг Scope 1, Scope 2, Scope 3 хүрээнд ангилж тодорхойлно.
- Цаашид жил бүр уур амьсгалын эрсдэлийн үнэлгээг өмнөх оны болон суурь үзүүлэлттэй харьцуулан ОУ-ын стандартын дагуу хэмжиж, хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж, оролцогч талуудад ил тод тайлагнана.



Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?

Өмнө дурдсанчлан Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 2021 оноос эхлэн Тогтвортой байдал, БОНЗ-ын тайланг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагатай гэрээлэн боловсруулж, БОНЗ-ын гүйцэтгэлээ үнэлүүлэн тайлагнаж байна. 2021 оны БОНЗ-ын тайланг “Ризиленс Консалтинг Сервик” ХХК боловсруулж, баталгаажуулсан бол 2022 оны БОНЗ-ын тайланг “Антифражайл” ХХК боловсруулж, хөндлөнгийн үнэлгээ өгч, баталгаажуулж байна.

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? Үүнд, хүний эрх болон бизнесийн тунхаглал орно.

Компани нь одоогоор тогтвортой хөгжлийн чиглэлд үйл ажиллагаа явуулдаг дотоодын болон ОУ-ын байгууллага, холбоодын гишүүн биш байна.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг бодитоор хэрэгжүүлэхэд техникийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, чадавх бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд туслалцаа үзүүлдэг маш олон ОУБ байдаг бөгөөд гишүүнээр элсэх, тодорхой зарчмуудыг дагаж мөрдөх үүрэг хүлээснээр компанийндотоод чадавхыг бэхжүүлэх, нэр хүндээ өсгөх, үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа авах олон боломж нээгддэг тул өөрсдийн үйл ажиллагаатай нийцсэн ОУ-ын байгууллага эсвэл санаачилгад нэгдэх, тууштай хамтран ажиллах замаар БОНЗ, тогтвортой байдлын гүйцэтгэлээ сайжруулах.



Бүлэг

2

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Эрчим хүч

Хүлэмжийн хийн ялгарал

Уур амьсгалын эрсдэл

Ус

Хог хаягдал

Биологийн олон янз байдал

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хоолны үйлдвэр, хүйтэн хэлхээт түгээлтийн төв нь Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэж менежментийн төлөвлөгөөгөө батлуулсан бөгөөд 2023 онд хугацаа нь дуусч байгаа учир дахин шинэчлэн хийлгэж байна.

ЭРЧИМ ХҮЧ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК болон Сэнтрал Фүүдс ХХК нь өөрийн оффисоос гадна 285 конвинеиенс салбар дэлгүүр, нэг хоолны үйлдвэр, түүний дэргэдэх хүйтэн хэлхээт түгээлтийн төв, мөн хэвийн температурын горимтой бүтээгдэхүүн түгээлтийн төв гэсэн объектуудад үйл ажиллагаа явуулдаг.


Эдгээр объектууд нь 2022 оны 1-р сарын 1-нээс 12-р сарын 31-ны өдрийг дуустал нийтдээ (тээврийн зорилгоор хэрэглэсэн түлшийг тооцохгүйгээр) 133,972,214 кВт.ц-ийн эрчим хүч хэрэглэсэн бөгөөд үүнээс 13,044,404 кВт.ц нь цахилгаан, 435,337 гДж нь дулаан байна.

Эрчим хүчний үзүүлэлтүүд	Эрчим хүчний хэрэглээ, кВт.ц/жил	Эрчим хүчний зардал, ₮
Е 1.1: Нийт эрчим хүчний хэрэглээ	133,972,214 кВт.ц	2,553,769,703.5
Е 1.2: Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ	13,044,404 кВт.ц	2,322,571,913.3
Е 1.3: Дулааны нийт зарцуулалтын хэмжээ	435,337 гДж (дүйцүүлбэл 120,927,811 кВт.ц)	231,197,790.2
Е 1.4: Түлшний нийт зарцуулалтын хэмжээ		218,495,708.0
1. Халаах зорилгоор хэрэглэсэн түлш буюу нүүрс, хий	14 тн сайжруулсан нүүрс 66,450 л газ	218,495,708.0
2. Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	299,955.6 л дизель	
Е 1.5: Хүрэн буюу СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	100%	
Е 1.6: СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%	


Объектууд бүгд цахилгаанаа төвийн шугамаас шийддэг. Хоолны үйлдвэр, хүйтэн хэлхээт түгээлтийн төв нь өндөр хүчдэлийн шугамаас татсан хүчдэл буулгагч бүхий тусдаа дэд бүтцийг барьсан. Хөргүүрүүд цахилгааны тэжээлээр шийдэгдсэн бол

тоног төхөөрөмжүүдийг газар, дулаанаа нам даралтын зуухаар шийдсэн. Нам даралтын зуух тортог баригчтай, сайжруулсан түлш түлдэг. Тог тасрах, газын хоолой бөглөрөх зэрэг нэмэлт эрчим хүчний үүсгүүр шаардлагатай тохиолдолд түрээсийн дизель генератор ажиллуулан хөлдөхөөс сэргийлдэг. Дизель генератор нь өөрийн нөөцийн савтай, агаарын филтэртэй учир яндангаас агаар бохирдуулагч бодисууд ялгарууддаггүй.

2021 онтой харьцуулахад 2022 оны цахилгааны хэрэглээ 60%-иар нэмэгдсэн нь дэлгүүр, хоолны үйлдвэрийн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэнтэй холбоотой. Нийт цахилгааны хэрэглээний 86.3%-ийг сүлжээ дэлгүүрүүд, 13.5%-ийг хоолны үйлдвэр, 0.1%-ийг оффис, 0.1 хүрэхгүй хувийг хэвийн горимт түгээлтийн төв эзлэж байна.



Хүйтэн хэлхээт түгээлтийн төв нь 9-р сард захиалга бэлтгэх хагас автомат системийг нэвтрүүлснээр бүтээмж 30-40% ихэсч, эрчим хүчний хэрэглээ бага хэмжээгээр нэмэгджээ. Энэхүү системийг хэвийн горимт түгээлтийн төвд суурилуулан 2023 онд үйл ажиллагаанд нэвтрүүлэх төлөвлөгөөтэй.




Цаашдаа найдвартай эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор 50 тонны багтаамжтай газын байгууламж барих бүтээн байгуулалтын ажил явагдаж байна. Мөн үйлдвэрийн дээвэр дээр нарны эрчим хүчний үүсгүүр суурилуулах талаар боломжийг судалж эхлээд байна.

ЭРЧИМШИЛ

Нийт эрчим хүчний хэрэглээний 86.3%-ийг салбар дэлгүүрүүд эзэлж байгаа бөгөөд эрчимшлийг тооцож үзвэл дэлгүүрт 1 хэрэглэгчид үйлчлэхэд 43.93 кВт.ц ашигладаг, 1,000,000 төгрөгийн борлуулалт бүрд 512.75 кВт.ц ашигладаг гэсэн тооцоо гарна. Энэ нь 2019 онтой харьцуулахад 1 хэрэглэгчид үйлчлэхэд ашигладаг байсан эрчим хүчний хэмжээ 2 дахин, 1 сая төгрөгийн борлуулалт хийхэд зарцуулдаг эрчим хүч 5 дахин тус тус буурсан үзүүлэлт буюу компанийн үр ашиг нэмэгдэж, эрчим хүчний зарцуулалтын үр ашиг мөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Үйлдвэрийн хувьд нийт эрчим хүчний 13.5%-ийг хэрэглэдэг бөгөөд үйлдвэрлэж буй нэгж бүтээгдэхүүн бүрт 0.33 кВт.ц эрчим хүч ашиглаж байгаа нь өмнөх оноос бага зэрэг буурсан үзүүлэлт юм. Энэхүү үзүүлэлтээс бүтээгдэхүүн, үйлчилгээ эрчим хүчний үр ашгийг харж, түүхэн мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой байдаг.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ



CU салбар дэлгүүрүүд бүгд тогны тоолууртай бөгөөд тог тасарсан тохиолдолд 1.5 цаг цахилгаанаа барих чадалтай тог баригчийг суурилуулсан байна.

Тог тасарсан үед ашиглах оффлайн ПОС төхөөрөмж, болон кассийн шийдэлтэй.

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЦАХИЛГААН БАРААНЫ ХЭРЭГЛЭЭ

Хоолны үйлдвэрийн хувьд тоног төхөөрөмжүүд, мөн агааржуулагч, хөргүүрийн системүүд олон төрлийн температурын горим үүсгэн ажилладаг ба барилгын температурын хяналтын системээр хянагдаж байдаг.

Хамгийн их цахилгаан зарцуулалтад нөлөөлж байгаа зүйлсийг доор жагсаав.

Цахилгаан бараа	Тоо ширхэг	Ашигт үйлийн коэффициент
CU салбар дэлгүүрүүд		
Хөргүүр (Хүнс, шингэн хүнс, зайрмаг)	2,084	34-42%
Агааржуулагч	989	34-42%
Үйлдвэр		
Хөргүүр		
Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж	n/a	30 – 40%

Сэнтрал экспресс Си Ви Эс ХК нь түгээлтээ гэрээт компаниар шийддэг бөгөөд компанийнудирдлага доорх бүх хүргэлтийн үйлчилгээ өглөөний 4-8 цагийн хооронд хийгдэж дуусдаг. Ингэхдээ дараах ерөнхий маршрутаар зорчдог:

**ТҮЛШ БАГА
ЗАРЦУУЛДАГ,
АГААРЫН
БОХИРДОЛ
БАГАТАЙ
ТЭЭВЭР**

1. Хоол ханган нийлүүлэгч үйлдвэрүүд, хөлдөөсөн импортын хүнс нийлүүлэгчид хотын зүүн захад байрлах хүйтэн хэлхээт түгээлтийн төврүү, түгээлтийн төвөөс салбар дэлгүүрүүдрүү 39 ш хүйтэн хөргүүрт машинаар өдөрт 200 гаран нэр төрлийн 80,000 – 100,000 хоолыг,
2. Энгийн горимт хүнс нийлүүлэгчид хотын баруун урд захад байрлах түгээлтийн төврүү, түгээлтийн төвөөс салбар дэлгүүрүүдрүү 29 ш энгийн ачааны машинаар тус тус тээвэрлэдэг.

Мөн энэ онд хүйтэн хэлхээний түгээлтийн дэд бүтцийг байгуулсан ба улмаар 400 гаруй үйлдвэрлэгч, бэлтгэн нийлүүлэгчдийн бүтээгдэхүүний түгээлтийг төвлөрүүлэн, 6,600,000 орчим зорчих хөдөлгөөнийг 132,000 болтол бууруулж нийслэл хотын замын хөдөлгөөний ачааллыг бууруулахад хувь нэмрээ орууллаа. Ингэснээр энгийн үетэй харьцуулахад агаарын бохирдлыг 98% бууруулж буй арга хэмжээг нэвтрүүлэхэд зарцуулсан 15 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт болжээ.

Түгжрэлгүй үед түгээлт хийснээр 4 дахин цаг хэмнэхээс гадна шатахуун зарцуулалтыг 80%-иар бууруулдаг (Трэйбэр эт ал, 2007). Илүү бага дизель зарцуулахаас гадна түгжрэлд удаан зогсохгүй, тогтмол хурдаар явж байгаа учир хэмнэсэн хугацааны турш ялгарах байсан дизелийн утаанаас сэргийлж агаарын бохирдол, хүлэмжийн хийн ялгарлыг тэр хэрээр бууруулж байна.

Түүнчлэн түгээлтийн төвд тээврийн смарт систем хэрэгжиж эхэлснээр нийт зарцуулсан бензин, туулсан зам гэх мэт олон төрлийн мэдээллийг бүртгэж, тооцоолох боломжтой болгохоор ажиллаж байна.

ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дэлгүүрүүд тоног төхөөрөмжөө өдөрт дунджаар 3 цаг унтраадаг: 2021 оноос эхлэн дэлгүүрүүд ачаалал багатай цагууддаа буюу байршлаас хамааран дунджаар шөнийн 2-с 5 цагуудын хооронд ашиглагдахгүй тоног төхөөрөмжүүдийг унтраах арга хэмжээг аван ажиллаж байна. Үүнд салбар дэлгүүрийн хоол боловсруулах хэсгийн төхөөрөмжүүд багтана.

Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийдэг: Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг өдөр тутам, тогтмол хяналт хийж хэвийн, үр ашигтай үйл ажиллагааг ханган ажиллаж байгаа нь зориулалтаас илүү их цахилгаан зарцуулахгүй, үр ашигтай байдлыг хангаж байна.

Боломжтой үед байгалийн гэрэл ашигладаг: Түгээлтийн төв нь нартай үед өдрийн цагаар талбайн гэрэлтүүлгийн унтрааж байгалийн гэрлийг ашигласнаар 4,200 м2 бүхий талбайг гэрэлтүүлэх эрчим хүчнийг хэмнэж байгаа хэрэг юм.

100% ЛЭД гэрлүүд суурилуулсан: Дэлгүүр, үйлдвэрлэлийн гэрлүүд нь тодорхой стандартыг барьдаг бөгөөд эрчим хүчний үр ашигтай ЛЭД гэрэлтүүлэгтэй.

Үйлдвэрийн байранд эрчим хүч хэмнэхэд уриалсан тэмдэглэгээнүүд байрладаг.

Ханган нийлүүлэгчдийн эрчим хүч хэмнэх үйл ажиллагаа. 2022 оны эцсийн байдлаар Сэнтрал Экспресс компанид ханган нийлүүлэгч нийт дотоодын 17 хоол үйлдвэрлэгч байгаа бөгөөд хийсэн ярилцлагын үр дүнд дараах эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд сонгох,
- Эрчим хүчний хэмнэлттэй гэрэлтүүлэг сонгож хэрэглэх,
- Ажиллаагүй цагт бүх гэрэлтүүлэг, тоног төхөөрөмжийг унтраах,
- Өөрийн өмчлөлийн үйлдвэрийн барилгыг засварлаж, дулаан алдагдал бууруулах арга хэмжээ.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Эрчим хүчний мэдээллийг бүртгэж, тайлагнаж хянах менежментийн системтэй болох: Ихэнх объектууд бие даасан цахилгааны тоолууртай бөгөөд түрээслэгчээс тоолуур хариуцдаг тохиолдолд эрчим хүчний хэрэглээний мэдээллийг авах зохицуулалт хийснээр тоон мэдээллийг бүртгэх боломжтой. Ингэхдээ компанийн өгөгдөл, мэдээлэл бүртгэлийн системд ЭХ-ний хэрэглээг цахилгаан, дулаан, хөргүүр, шаардлагатай тохиолдолд уурын хэрэглээг тус бүрт нь бүртгэх.

СЭХ-ний эх үүсвэрийг судалж дулаанаа шийдснээр нүүрс, байгалийн хийн хэрэглээг бууруулах: Жишээ нь, дулааны насос, газрын гүний дулаан, нар, салхины эрчим хүч зэрэг.

Дараах зүйлсийг анхаарч “худалдан авалтын журам”-д өөрчлөлт оруулах:


Хөргүүр: Ханган нийлүүлэгчээс суурилуулж буй эсвэл худалдан авалтын хөргүүр болон бусад цахилгаан бараанд цахилгааны хэрэглээ (болон урсгал зардал) бага байх шаардлага тавих, мөн өөрсдийн худалдан авч буй хөргөгч, хөлдөөгч, агааржуулагчийг Energy Star эсвэл эрчим хүч хэмнэлтийн рейтингтэй хувилбарыг сонгох,

ЭХ-ний хэмнэлттэй холбоотой агуулгыг ажилчид, харилцагч нарт ордог сургалтын материалд оруулах. Жишээ нь: ямар үед цахилгаан барааны эрчим хүчний хэрэглээ өсдөг, дуудлагын төвд ирдэг эрчим хүч, цахилгаан бараатай холбоотой түгээмэл асуудлуудыг танилцуулж, зааварчилгааг өгөх.

Нэгдсэн агуулахаас түгээлтийн төврүү хүргэх зарчмыг нэвтрүүлэх: CU-д бараа нийлүүлэгчид өөр өөрийн агуулахаас CU - түгээлтийн төврүү хүргэлт хийдэг бөгөөд жижиг нийлүүлэгчдийн хувьд ашиггүй тээвэрлэх нөхцөлүүд үүсдэг учир байршлаас хамааран жижиг дунд нийлүүлэгчдийн агуулгыг нэг газар байрлахаар шийдэж өгөх боломжтой.

Тээврийн үр ашгийн нэмэгдүүлэх: Түгээлтийн машинд Евро-5 түлш ашиглах, насжилт багатай тээврийн хэрэгсэл сонгох

Ханган нийлүүлэгч үйлдвэрүүдэд эрчим хүчний хэрэглээгээ хэмжиж, тайлагнах, хянах шаардлага тавих.




ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

E 2.1: Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн. Үүнээс:	109,253.9тнCO _{2e}
	1-р хүрээний (Шууд)	2,030,695.12 кгCO _{2e}
	2-р хүрээний (Шууд бус эрчим хүч)	107,223,228.33 кгCO _{2e}
E 2.2: Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас бууруулсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	0 CO _{2e} /тонн
E 2.3: Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт) бууралт	0 тнCO _{2e}


Энэхүү тайлангийн хүрээнд хүлэмжийн хийн шууд бус (3-р хүрээний) ялгарлыг тооцох боломжгүй учир өөрийн үйлдвэрлэсэн эрчим хүчнээс ялгарах (1-р хүрээний) болон өөр бусад эх үүсвэрээс авч буй хэрэглээний эрчим хүчний (2-р хүрээний) хүлэмжийн хийг бэлэн байгаа өгөгдлүүд дээр үндэслэн тооцлоо. Бүрдлийн хувьд харахад нийт эрчим хүчний хэрэглээн дэх өөрийн үйлдвэрлэж буй буюу газ, сайжруулсан түлшний хэрэглээ бага байгаа учир 2-р хүрээний хүлэмжийн хийн ялгарал өндөр байна.

Тооцоонд орсон өгөгдөл	Цуглуулах боломжгүй, тооцоолоогүй мэдээлэл
1-р хүрээ: <ul style="list-style-type: none"> Эрчим хүчний хэрэглээ: <ul style="list-style-type: none"> Хоолны үйлдвэрт ашиглаж буй Газ, нүүрс, дизель Түлшний хэрэглээ: <ul style="list-style-type: none"> Ажилтнуудын нэгдсэн автобус. 2-р хүрээ: <ul style="list-style-type: none"> Эрчим хүчний хэрэглээ: <ul style="list-style-type: none"> 285 дэлгүүр, 1 хоолны үйлдвэр, 2 түгээлтийн төв Түлшний хэрэглээ: <ul style="list-style-type: none"> Түгээлтийн машин, 	1-р хүрээ: <ul style="list-style-type: none"> Хөргөлтийн шингэний ялгарал, алдагдал, Томилолтоор гадаад, дотоодод аяласан тээвэр, Үйл ажиллагаанаас санаатай болон санамсаргүй ялгарч буй бусад. 2-р хүрээ: <ul style="list-style-type: none"> Монгол ханган нийлүүлэгчдийн үйлдвэрлэлийн ялгарал. 3-р хүрээ: <ul style="list-style-type: none"> Ландфилд хаясан нийт хаягдал. Зарж борлуулж буй импортын барааны үйлдвэрлэл, Үйлдвэрлэл, үйл ажиллагаанаас ялгарсан хүнсний болон бусад хог хаягдал, нарийвчилсан ангиллаараа (органик, ахуйн, хуванцар, шил, цаас г.м.), Зарж борлуулсан бүтээгдэхүүний хаягдал (ангиллаараа), түүний боловсруулалт, Тооцоонд ороогүй бусад тээвэр.

1-р хүрээний хүлэмжийн хийн тооцоололд өөрийн үйл ажиллагаа буюу зэрэг мэдээллийг оролцуулан тооцоог хийсэн. Үүнд зарж борлуулж буй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх ба хаягдлыг боловсруулахад гарч буй хүлэмжийн хийн ялгарал, бусад тээвэр, болон хаягдлын задаргааны мэдээлэл байхгүй учир тооцоонд ороогүй болно.



Өмнөх жилүүдийн өгөгдөл, хүлэмжийн хийн тооцоолол хийгдсэн суурь жил байхгүй учир хүлэмжийн хий бууруулах арга хэмжээ авсан хэдий ч тухайн бууралтыг хэмжиж, тооцоолох боломжгүй байна.



Зарцуулалт	Хүлэмжийн хийн ялгарал, кгCO _{2e}	Хүрээ
Эрчим хүч		
Цахилгаан	10,403,401.15	2
Дулаан	96,007,733.31	2
Сайжруулсан нүүрс (лигнит)	45,088.39	2
Газ (LPG)	107,097.48	1
Нийт	106,563,320.33	
Тээвэр		
Түгээлтийн машин	812,093.87	2
Ажилчдын тээвэр	1,878,509.25	1
Нийт	2,690,603.12	
НИЙТ	109,253,923.45	1, 2

ЭРЧИМШИЛ

Нийт хүлэмжийн хийн эрчимшлийг тооцож үзвэл 1 хэрэглэгчид үйлчлэхэд 34.63 кгCO_{2e} ашигладаг, 1,000,000 төгрөгийн борлуулалт бүрт 410.2 кгCO_{2e} ашигладаг гэсэн тооцоо гарна.

Үйлдвэрийн хувьд үйлдвэрлэж буй нэгж бүтээгдэхүүн бүрт 0.21 кгCO_{2e} хүлэмжийн хийн эрчимшилтэй байгаа нь олон улсын жишгээс бага дүн юм.

Хүлэмжийн хийн бүртгэл, тооллогын системтэй болох: Дээрх хүснэгтэд байгаа мэдээлэл болон бусад өөрсдөд чухал мэдээлэл, үзүүлэлтүүдийг тодорхойлж, нэгдсэн байдлаар цуглуулах, бүртгэлжүүлэх, тооцох, хянах төлөвлөгөө гаргах хэрэгтэй.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Дараах зүйлсийг анхаарч “худалдан авалтын журам”-д өөрчлөлт оруулах:

Хөргөлтийн шингэний дулаан барих потенциал: Олон улсад R-410 (гидрофлорокарбон нэгдлийн) хөргөлтийн шингэнийг их хэмжээний хүлэмжийн хий ялгаруулдгаас болоод татгалзаж эхэлсэн учир шинээр худалдан авах агааржуулагч, хөргөгч, хөлдөөгчийг A2L бүлгийн буюу дулаан барих потенциал багатай, эсвэл энгийн нэгдэлт (пропан, аммон гэх мэт) хөргөлтийн шингэн ашигладаг загваруудыг сонгох, тухайн төхөөрөмжийн хөргөлтийн шингэний дулаан барих потенциал (GWP)-ийг анхаарах талаар тусгах хэрэгтэй.



УУР АМЬСГАЛЫН ЭРСДЭЛ





Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?

Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)



Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн



Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/ алхмуудыг тодорхойлсон уу?

Компанийн уур амьсгалын өөрчлөлтөд өртөх эрсдэл бүхий асуудлуудыг стресс тест хийж тодорхойлох,

Тухайн стресс тестээс гарч ирсэн асуудал, түүнээс урьдчилан сэргийлэх, дасан зохицохтой холбоотой арга хэмжээг өөрийн байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого стратегидаа тусгах, Холбогдох асуудал, мэдлэг, мэдээллийг шаардлагатай талуудад мэдээлэх, сургалтын материалд агуулгыг тусгах.

**САЙЖРУУЛАХ
ЗӨВЛӨМЖ**

УС



УСАН ХАНГАМЖ

Төвлөрсөн цэвэр, бохирын системд холбогдоогүй цөөн хэдэн CU дэлгүүрүүд хотын захаар байрлах бөгөөд зөөврийн усан хангамжаар шийдсэн байдаг. Хүнсний үйлдвэр мөн зөөврөөр усаа шийдсэн бөгөөд цэвэр, бохир төвийн шугамтай холбогдох зорилгоор дэд бүтцээ байгуулсан бөгөөд 10 тонны хэмжээтэй усны танктай. 2023 онд хүчин чадлыг нэмэгдүүлэн, нэмэлт танк, хуримтлуур бий болгож нөөцлөн ашиглахаар төлөвлөсөн. Хоолны үйлдвэрт ашиглагдах ус 4 төрлийн мембран филтрээр физик, хими, микробиологийн цэвэршүүлэлт хийгдэн ашиглагддаг, филтрийг жилдээ нэг сольдог. Усны чанарыг Эрүүл ахуйн журмын дагуу улирал бүр холбогдох байгууллагаар шинжилгээнд хамруулдаг. Үйлдвэрээс гарах хаягдал ус бохирын төвлөрсөн шугамд нийлүүлэгддэг.


Конвениенс дэлгүүрүүдийн хувьд цэвэр усны хэрэглээ нь халуун цай болон бусад найруулдаг уух зүйлс бэлтгэх, цэвэрлэгээ хийх, болон ариун цэврийн өрөөний хэрэглээнээс бүрдэнэ.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Хоолны үйлдвэрийн усны хэрэглээ нь хоол үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, ахуйн хэрэглээ, лабораторийн цэвэрлэгээ гэсэн гол зориулалтаар хэрэглэнэ.

Дэлгүүрүүд цэвэрлэгээгээ ээлж солигдоход буюу ажлын цагийн хуваариас хамааран 2-3 удаа цэвэрлэдэг бөгөөд эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан цэвэрлэгээний бодисыг стандарт ажиллагааны зааврын дагуу ашигладаг. Үйлдвэрийн хувьд өдөртөө нэг тогтмол цэвэрлэгээг хийдэг бөгөөд мэргэжлийн цэвэрлэгээний байгууллагаар улиралдаа нэг их цэвэрлэгээ хийлгэдэг.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ




САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Ус хэмнэх үйл ажиллагаа

Ус хэмнэх технологи: Мэдрэгчтэй угаалтуурын тоог 8-р нэмж, 20 суултуурын усны таталтыг 50% -р бууруулсан.


CU дэлгүүрийн ариун цэврийн өрөөнүүдийн суултуурын усны таталтыг бууруулах технологийн арга хэмжээ авах.

ХОГ ХАЯГДАЛ



Бүх объектууд харьяа дүүргийн холбогдох тохижилт үйлчилгээний төрийн компаниудтай гэрээлсэн бөгөөд зарим СУ дэлгүүрүүдийн хувьд түрээслэгч хаягдлыг хариуцдаг. Түүврийн судалгаа, үзлэгт хамрагдсан объектууд бүгд хүчин төгөлдөр гэрээтэй байсан.

Эх үүсвэр	Үйл ажиллагаа	Ялгарах хог хаягдлын төрөл
Дэлгүүр	Бүх төрлийн бараа бүтээгдэхүүн зарж борлуулах	Сав, баглаа, боодол: хуванцар, гялгар, цаас
	Хоол бэлтгэл, хоол зарж борлуулах	Хүнсний шингэн, хатуу хаягдал (органик), нэг удаагийн хуванцар хэрэгслүүд, салфетка
	Кассын баримт гаргах	Кассын баримтын цаас
	Хугацаа дууссан/Чанарын доголдолтой бараа актлах	Хүнсний шингэн, хатуу хаягдал (органик), сав, баглаа боодол
	Ариун цэвэр, ахуйн хаягдал	Ариун цэврийн хэрэглэлүүд
	Бичиг хэрэг	Цаас



Үйлдвэр, хүйтэн хэлхээт түгээлтийн төв	Хоолны үйлдвэрлэл	Ногооны хальс, хаягдал тос, түүхий эдийн хайрцаг, сав баглаа боодол, шуудай, төмөр лаазны хаягдал, үйлдвэрлэлийн үед чанарын доголдолтой, стандартад нийцээгүй учир акталсан хүнсний хаягдал,
	Лабораторийн шинжилгээ	Хоолны дээж, лабораторийн урвалж, бодисын хаягдал
	Эрүүл ахуйг хангах	Маск, бээлий гэх мэт эрүүл ахуйн чиглэлийн нэг удаагийн хэрэглэлүүд, хагас жилд 1 солигддог үйлдвэрийн ажилчдын хувцас,
	Галлагаа	Үнс
	Ариун цэвэр, ахуйн хаягдал	Ариун цэврийн хэрэглэлүүд
	Бичиг хэрэг	Цаас
Хэвийн горимт түгээлтийн төв	Агуулахын бөөний барааг жижиглэнгээр дэлгүүрийн хэрэгцээнд бэлтгэх	Олон төрлийн ундааны баглаа гялгар, бусад кардон, цаасан сав баглаа боодол
	Ариун цэвэр, ахуйн хаягдал	Ариун цэврийн хэрэглэлүүд
	Бичиг хэрэг	Цаас

Салбар дэлгүүрээс ялгарах хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаггүй бөгөөд дэлгүүрт шингэн болон хуурай гэсэн хогийн савууд байршсан байдаг.

Салбар дэлгүүрийн үйл ажиллагаанаас тогтмол үүсдэг дахин боловсруулах боломжгүй хаягдал байгаа нь шохойн цаас бүхий төлбөрийн баримт байна.

САЛБАР ДЭЛГҮҮР

Салбар дэлгүүрийн хог хаягдлын хэмжээг хэмждэггүй. Цөөн салбаруудын хэрэгжүүлж буй дахин боловсруулах арга хэмжээг албан ёсоор бүртгэдэггүй учир энэхүү тоог гаргаж баталгаажуулах шаардлагатай. Түүнчлэн хаягдлын бүтцийг ангилж, хэдэн хувь нь дахин боловсруулагдах боломжтой гэдгийг тодорхойлсноор хогны менежментийг хийх боломжтой болох юм.

CU конвиниенс дэлгүүр нь дэлхийд хог хаягдал ангилан ялгалт, дахин боловсруулалтаараа тэргүүлэх орнуудын нэг БНСУ-аас эхтэй, тухайн систем, дэд бүтцэд тулгуурлан хөгжүүлсэн импортын бараа бүтээгдэхүүнүүдийг оруулж ирдэг. Энэ нь хог хаягдлын менежментийн хөгжил сул манай орны нөхцөлд өөр түвшний, маш тодорхой менежментийн үйл ажиллагааг шаардаж байна. Иймээс нэн тэргүүнд анхаарал өгч ажиллах шаардлагатай хүрээлэн буй орчны бүрдэл зүйл бол яалт ч үгүй хог хаягдлын асуудал юм.

Түгээлтийн төв нь картон хайрцгийг хаягдал болгожгүй дахин ашигладаг сайн туршлагатай. Мөн захиалга бэлтгэх хагас автомат системийг нэвтрүүлж эхэлсэн. Ингэснээр цаасны хэрэглээг 2 дахин багасгаж өдөрт дунджаар 3,000ш буюу 1.8 кг, жилдээ 630 кг бичгийн цаасны хэрэглээг багасгах боломж бий болж байна.

2021 онд Өнгө нэм ТББ-аас компанийн захиалгаар гаргасан Хог хаягдлын менежментийг сайжруулах зөвлөмжийн дагуу хогийн савыг үйлдвэр болон оффисын орчинд тодорхой байршилд байрлуулж, ариутгалын бүртгэлтэй болж, дахин боловсруулах боломж, хамтын ажиллагааг судлан ажиллаж байна.

СЭНТРАЛ ФҮҮДС


Сэнтрал Фүүдс компани мөн өөрийн Хог хаягдлын журамтай бөгөөд хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин ашиглах, тээвэрлэх зэрэг шат бүрийг журамдаа тусгасан байна. Үүний дагуу хоолны үйлдвэрлэл болон оффисын хэсгүүдэд ангилан ялгах хогийн савуудыг байрлуулж, хог түр байршуулах, хог хадгалах агуулахыг гаргасан. Гаднаа хаягдлын байгууламжтай бөгөөд дотроо 3 төрлөөр ангилсан байдаг.

Эрүүл ахуйн журмын хавсралтаар батлагдсан хог хаягдлын ачилт, ариутгалын бүртгэл хийдэг бөгөөд үүний хүрээнд 7 хоног тутам 2-3 удаа гэрээт байгууллагаас ачилт хийдэг. Дахин боловсруулах үйлдвэрүүд ирж авдаггүй. Харин үйлдвэрээс гардаг хаягдал тосыг ашиглах боломжтой үйлдвэрт нийлүүлэхээр ярилцаж байна. Лабораторийн хаягдлыг ариутгаж хоргүйжүүлсэний дараагаар энгийн хог хаягдалтай хамт хаяж байна. 7 хоногтоо дунджаар 20 тонн хаягдал ялгардаг.

Эх үүсвэр дээр ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг дахин ашиглагдах болон ашиглагдахгүй байдлаар ангилан ялгах ба хаягдлыг 5 ангилан цуглуулахаар зааж өгсөн байдаг. Үүнд:

- Ногоон буюу дахивар хаягдал
- Цэнхэр буюу цаасны хаягдал
- Бор буюу хүнсний, органик хаягдал
- Хар буюу бусад хог хаягдал
- Улаан буюу аюултай хог хаягдал.

Ийнхүү ангилсан ч дахивар авдаг үйлдвэрүүд ложистикийн асуудлаа шийдээгүй байгаа учир дахин боловсруулагдах боломжгүй байна. Мөн үйлдвэрлэлийн явцад ялгарах хүнсний хаягдлыг ангилахад эрүүл ахуйтай холбоотой асуудал үүсдэг. МХЕГ-н шаардлагын дагуу хоолны үйлдвэрлэлийн хэсгийн ойролцоо ахуйн хогийн сав байрлах хориотой учир ажилчид цаг тутам нэг удаагийн хэрэгслээ солихдоо хол байрлах хогийн савруу биш хоолны хаягдалруу хаяснаас дахин ашиглагдах боломжгүй болдог. Хоолны үйлдвэрлэлээс ялгарч буй хамгийн хүлэмжийн хийн потенциал өндөртэй хаягдал бол хүнсний буюу органик хаягдал. Хүнс хаягдаж, дахин задрахдаа нүүрстөрөгчийн хийнээс 8 дахин илүү дулаан барих потенциалтай метаны хийг ялгаруулдаг учир энэхүү асуудалд гаргалгаа олох нь маш чухал.



ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИД

Компани нь хамтран ажилладаг ханган нийлүүлэгчидтэй хийх мастер гэрээндээ "ажлыг гүйцэтгэхтэй холбогдон гарсан аливаа хог хаягдлыг заасан цэгт хаяж, өөрийн хүчээр зайлуулж цэвэрлэх, мөн гэрээлэгч нийтийн талбайд ямар нэгэн хаягдал үүсгэхгүй, бохирдуулахгүй, үүссэн хаягдал, бохирдлыг бүрэн цэвэрлэж, орчны хэвийн нөхцлийг тухайн ажлын өдөрт нь сэргээж, цэвэрлэх шаардлагыг тавьдаг.

Компани кардон хайрцагийг дахин ашиглах тохиолдол элбэг байна. Жишээ нь түгээлтийн төвөөс дэлгүүрүүдрүү жижиглэнгээр түгээлт хийхэд хайрцгийг дахин ашиглах, харин хоёрдогч түүхий эд ашигладаг иргэд зарим дэлгүүрүүдээс худалдаж аван маск зэрэг нэг удаагийн хэрэгслүүдийн зардлыг нөхөх тохиолдлууд бий.

ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

GP батарей компанитай хамтран 100кг батарейны хаягдлыг цуглуулж, тушаасан.

"Аягагүй кофе" хөтөлбөрийн хүрээнд 83,307 үйлчлүүлэгчид нийт 90,415 ширхэг аяганы хог хаягдал үүсэхээс сэргийлжээ.

Хагас автоматжсан захиалгын системийг нэвтрүүлснээр жилд дор хаяж 630 кг хаягдал цаас булагдахаас сэргийлэх төлөвлөгөөтэй.

Хаягдал тосыг савангийн үйлдвэрт нийлүүлэхээр ярилцаж байна.


ХҮНСНИЙ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ САВАЛГАА

Сэндвичний савалгааг MAP технологи буюу савалгаан дахь агаарын горимыг өөрчлөн тохируулснаар бактери, микро-организм үржих боломжгүй, исэлдэхгүй орчинг үүсгэж, хадгалах хугацааг уртасгадаг.

ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН САЙН ЖИШЭЭ

Ингэснээр эрүүл, чанартай хүнсийг илүү урт хугацаанд хадгалж, хэрэглэгчдэд хүрч амжилгүй актлагдах хүнсний хаягдал үүсэхээс сэргийлж байна.

Хоол хүнс хаягдахдаа агаар мандалд дулаанаа барих чадвар өндөртэй хүлэмжийн хий болох метаныг ялгаруулж байдаг учир хүнсний хаягдал гаргахгүй байх нь уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлж буй маш том хувь нэмэр юм. Үүнийг олон улсын зорилтуудад мөн тусгасан байдаг. Жишээ нь, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 12-н хүрээнд 2030 он гэхэд нийт хаягдаж буй хүнсний хог хаягдлыг 50% бууруулах зорилт тавьсан.



Хоолны үйлдвэрээс гадна Хонхор орчимд хүйтэн хэлхээг түшиглэн байрлах үйлдвэрлэл эрхэлж буй ханган нийлүүлэгчдээс ижил төстэй болон нэгэн төрлийн хог хаягдлууд, тэр дундаа дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хог хаягдлууд гарч байгааг бүсчилсэн байдлаар менежмент хийж, ложистикийн шийдэл гаргах, хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах. Ингэхдээ Нийслэлтэй хамтарч ажиллах.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Хүнсний хаягдлыг ангилж, тусад нь бүртгэдэг болох.

Хоолны үйлдвэрт хүнсний хаягдлыг компост хийх байгууламж барих

Төлбөрийн баримтны хэвлэлийг багасгах зорилгоор CU аппликейшнээр ибаримтаа авах, эсвэл ибаримт бүртгэгдэх зохицуулалт хийх

Хүнсний үйлдвэрлэгчдийн хадгалалтын хугацааг ашиглах сав баглаа, боодлын технологи нэвтрүүлэх боломжийг судлах

Хог хаягдлыг ангилан бүртгэхээс сэргийлж буй асуудлуудыг шийдэх: Үйлдвэрлэлийн явцад нэг удаагийн хэрэгслийн хаягдлыг хийх битүүмжлэлтэй сав байршуулах.

CU салбар дэлгүүрийн хог хаягдлын бүтцийн шинжилгээ хийлгэж, сардаа хэр их хог, хэдэн хувь нь дахин боловсруулах боломжтой гэдэг судалгааг хийлгэх шаардлагатай.


CU салбар дэлгүүрүүдийн сүлжээний нөлөөг ашиглан, хоёрдогч түүхий эд худалдан авдаг талуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх. Ингэхдээ шат дараатайгаар, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой маш тодорхой цөөн төрлийн хог хаягдлыг ангилан ялгуулах, олон нийтэд таниулах. Жишээ нь, эхний шатанд үйлчлүүлэгчид хөнгөн цагаан материалаар хийгдсэн ундааны лаазыг ангилж хаях. Түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулан ногоон байгууламж босгох гэх мэт. Дараагийн шатанд ус, ундааны савыг хаяхдаа хаягжуулалтын гялгар, тагны хуванцраас салган хаях гэх мэт.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

Хоолны үйлдвэрийн хувьд дуу чимээ, агаар, хөрсний бохирдол ялгаруулдаггүй, авто замын дэргэд байрлах бөгөөд биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай.

CU конвениенс дэлгүүрүүд дээр хийгдсэн судалгаанаас үзэхэд тайланг бичих үеийн 285 салбар дэлгүүрийн судалгаанаас харахад 90 салбар буюу 30% нь гадна талдаа ногоон байгууламж үүсгэх боломжтой талбайтай гэсэн хариу өгсөн. Харин тодорхой талбайд зориулан ногоон байгууламж барьсан тохиолдлыг хэмжиж баталгаажуулах тоон мэдээлэл байхгүй.

Хоолны үйлдвэрийн хувьд өөрийн талбайн 13.6%-д ногоон байгууламж тарьсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 7.6% өссөн үзүүлэлт юм.



САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Түгээлтийн төв, хоолны үйлдвэрийн газар, талбай, мод тарих талбайтай салбар дэлгүүрүүдэд ногоон байгууламжийг нэмэгдүүлж 30%-д хүргэх.

Дэлгүүрийн зөвлөмжид ногоон байгууламжийн эзлэх талбайг зааж өгөх, боломжгүй тохиолдолд дүйцүүлэн өөр газар тариалах шаардлага тавих.

Бүлэг

3

НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ

Хүний нөөцийн хөгжил
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
Эрх тэгш байдал
Хүртээмжтэй байдал
Нийгмийн хариуцлага, ил тод байдал
Тогтвортой өртгийн сүлжээний менежмент

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ



Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)

Сэнтрал Экспресс: **70%**

Сэнтрал Фүүдс: **72%**

Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо

Сэнтрал Экспресс: **1,912**

Сэнтрал Фүүдс: **27**





CU брэнд салбар дэлгүүрийн тоогоо нэмэгдүүлэхийн хэрээр шинэ ажлын байрыг ихээр бий болгож 2022 оны эцсийн байдлаар өмнөх онтой харьцуулахад 3,200 ажлын байрыг шинээр бий болгожээ. Монгол Улсад “цагийн ажил” гэх ойлголтыг нутагшуулж, өдгөө ажилтнуудын 52 хувийг цагийн ажилтнууд буюу дийлэнхийг оюутан залуус эзлэж байна. Оюутан залууст хичээлийнхээ хажуугаар тогтмол орлоготой, уян хатан цагийн хуваарийн дагуу өөрт ойр байршлаас ажиллах боломжийг олгодог давуу талтай.

Сүүлийн 12 сард менежер ба түүнээс дээш албан тушаалд дэвшсэн байдлыг хүйсээр ангилан харвал нийт албан тушаал дэвшсэн байдал эмэгтэйчүүд 52 хувийг эзлэж байна.

Харин сүүлийн 12 сард ажлаас чөлөөлөгдсөн байдлыг харвал нийт ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудад эмэгтэйчүүд 62.6 хувийг эзлэх бөгөөд сүүлийн 12 сард шинээр 1,852 хүн ажилд авснаас үүний 60.58 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна.

Шинээр бий болгосон ажлын байр, 2018-2022





Тушаал дэвшсэн байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эмэгтэй %
Сүүлийн 12 сарын хугацаанд Гүйцэтгэх удирдлагын түвшин рүү тушаал дэвшсэн нийт ажилтнуудын тоо	1	3	4	75.00%
Сүүлийн 12 сарын хугацаанд Дунд түвшний захирлын албан тушаалд дэвшсэн нийт ажилтнуудын тоо	5	1	6	16.67%
Сүүлийн 12 сарын хугацаанд Менежерийн албан тушаалд дэвшсэн нийт ажилтнуудын тоо	17	21	38	55.26%
Нийт менежер ба түүнээс дээш албан тушаалд дэвшсэн байдал	23	25	48	52.08%
Ажлаас чөлөөлөгдсөн байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эмэгтэй %
Сүүлийн 12 сарын хугацаанд Гүйцэтгэх удирдлагын албан тушаалаас чөлөөлөгдсөн нийт ажилтнуудын тоо	1	1	2	50.00%
Сүүлийн 12 сарын хугацаанд Дунд түвшний захирлын албан тушаалаас чөлөөлөгдсөн нийт ажилтнуудын тоо	1	1	2	50.00%
Сүүлийн 12 сарын хугацаанд Менежерийн албан тушаалаас чөлөөлөгдсөн нийт ажилтнуудын тоо	6	10	16	62.50%
Сүүлийн 12 сарын хугацаанд Entry-level буюу хамгийн бага албан тушаалаас чөлөөлөгдсөн нийт ажилтнуудын тоо	1,567	2,586	4,153	62.27%
Нийт ажлаас чөлөөлөгдсөн байдал	1,575	2,598	4,173	62.26%
Шинээр ажилд авсан байдал	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эмэгтэй %
Сүүлийн 12 сарын хугацаанд Гүйцэтгэх удирдлагын түвшинд "гаднаас шинээр" ажилд авсан нийт ажилтнуудын тоо	1	1	2	50.00%
Сүүлийн 12 сарын хугацаанд Дунд түвшний захирлын албан тушаалд "гаднаас шинээр" ажилд авсан нийт ажилтнуудын тоо	3	13	16	81.25%
Сүүлийн 12 сарын хугацаанд Менежерийн албан тушаалд "гаднаас шинээр" ажилд авсан нийт ажилтнуудын тоо	163	266	429	62.00%
Сүүлийн 12 сарын хугацаанд Entry-level буюу хамгийн бага албан тушаалд "гаднаас шинээр" ажилд авсан нийт ажилтнуудын тоо	563	842	1,405	59.93%
Нийт шинээр ажилд авсан байдал	730	1,122	1,852	60.58%

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?


Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 2020 оны 6-р сарын 3-ны Гүйцэтгэх захирлын А/20-29 тушаалаар анх Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогоо баталсан бөгөөд үүний хүрээнд дараах журам, зааварчилгааг баталсан байна. Үүнд:

1. ХАБЭА-н ерөнхий журам
2. Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл ашиглах журам
3. Аюулыг илрүүлэх, мэдээлэх, залруулах журам
4. ХАБЭА, БО үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, аюултай тохиолдол, осолд дөхсөн тохиолдлыг судлан бүртгэх журам
5. Галын аюулгүй байдлын журам
6. ХАБЭА-н дотоод хяналтын журам
7. ХАБЭА-н стандарт ажиллагааны зааварчилгаа
8. ХАБЭА-н сургалт, зааварчилгаа өгөх журам
9. ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн журам.

Компанийн ХАБЭА-н менежер нь Гүйцэтгэх захирлын удирдлага дор ХАБЭА-н удирдлагын системийг хариуцаж, холбогдох болон шаардлагатай бодлого, журам боловсруулж, хяналт, зөвлөгөөг өгч ажилладаг. Түүний дараа ХАБЭА-н ажилтнууд байх ба түгээлтийн төв ХАБЭА-н зөвлөлтэй, үйлдвэр орон тооны нэг ажилтантай байна. Энэхүү ажиллагаанд Үйл ажиллагаа хариуцсан захирал аюулгүй ажиллагааг хангаж хэрэгжүүлэх, албадын дарга, менежер, ахлах ажилтнууд аюулгүй ажиллагаанд манлайлал үзүүлэх үүрэгтэй. Ажилчид, гэрээт болон туслан гүйцэтгэгчид аюулгүй ажиллагааг хангаж өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулахгүй байх үүрэгтэй.

ХАБЭА-Н УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Үүний хүрээнд өглөө бүр дэлгүүр, үйлдвэр, түгээлтийн төвүүдэд товч хурал болдог ба өмнөх ээлжийн мэдээлэл, стандарт ажиллагааны зааварчилгаа, ХАБЭА-н зааварчилгааг өгдөг. Үйлдвэр, түгээлтийн төвийн ажилчид өглөө бүр ХАБЭА-н зааварчилгааг сонссон бүртгэлд гарын үсэг зурдаг. Дэлгүүрийн хувьд ээлж солигдох бүрт Нэгдсэн бүртгэлийн дэвтэрт өмнөх ээлжийн мэдээллийг багтаан, ээлжийн ахлах зааварчилгааг бичгэн болон аман байдлаар өгдөг.



Гэнэтийн ослын даатгалаас гадна гуравдагч этгээд болон хамааралтай этгээдүүдийн бие эрхтэний гэмтэл бэртэл, эрүүл мэнд, амь насанд учруулах хохирол, түүнчлэн эд хөрөнгийн эвдрэл, хохирлыг хамаарсан ерөнхий хариуцлагын даатгалтай. Мөн компани ханган нийлүүлэгч, гэрээт компаниудад тавих шаардлагын баримт бичигт ХАБЭА-ны шаардлагыг хангах талаар тусгасан байдаг.

Компани нийт ажилтнууддаа ХАБЭА-н сургалт тогтмол орж, гэнэтийн ослын даатгалд хамруулан эрүүл мэндийн шинжилгээнд хамруулдаг.


ХАБЭА сургалтыг жилдээ 1 ажилтанд дунджаар 5 цаг өгдөг бөгөөд ХАБЭА-ын мэдээллүүдийг тухай бүр холбогдох газруудад нь харагдахуйц байдлаар байрлуулсан байна.

Нийт 3,000 хүнийг тогтмол эрүүл ахуйн шаардлагын дагуу халдварт өвчний шинжилгээнд хамруулдаг ба холбогдох нэгж, ажилчдад дараах шинжилгээнүүдийг зохион байгуулсан. Үүнд эрүүл мэндийн хугацаат үзлэг 80, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг 391, хеликобактерийн тест 68, дүүргийн эрт илрүүлгийн шинжилгээнд 24 ажилчин хамруулсан.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Үйл ажиллагаа	Эрсдэл	Эрсдэлийн магадлал	Эрсдэлийн нөлөө
Дэлгүүр	Гал, цахилгааны аюул	Бага	Их
	Хоол бэлтгэлийн үед түлэгдэх	Бага	Бага
	Хоол бэлтгэлийн үед хуруу, гараа зүсэх	Дунд	Бага
	Бараа агуулахруу зөөх үед нуруу гэмтээх	Бага	Дунд
	Үйлчлүүлэгч ажилтны биед халдах	Дунд	Их
	Дэлгүүр хооронд бараа зөөвөрлөх үед гэмтэж бэртэх	Бага	Их
Үйлдвэр, хүйтэн хэлхээт түгээлтийн төв	Дулааны боловсруулалтын хэсэгт түлэгдэх	Бага	Дунд
	Шалан дээрх ус, шатан дээр халтирч унах	Дунд	Дунд
	Гал, цахилгааны аюул	Бага	Их
	Газ алдагдаж дэлбэрэх	Бага	Их
	Хордлого авах	Бага	Дунд
	Төхөөрөмжийн засвар, үйлчилгээг хийх явцад хуруу, гараа зүсэх	Дунд	Бага
Хэвийн горимт түгээлтийн төв	Форк лифт ажиллуулахдаа даац хэтрүүлэх, тогтворгүй ачилт хийх	Бага	Дунд
	Дээд давхрын өрөлт хийх явцад лифтээс унах	Бага	Их
	Машин тоног төхөөрөмжийн хөлд өртөх	Бага	Дунд
	Ачилтын талбай мөстсөн үед халтирч унах	Бага	Дунд
	Түгээлтийн машинд бараа ачих явцад бэртэж гэмтэх	Дунд	Дунд

НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ



БҮЛЭГ 3


ХАБЭА-Н ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛ, ТӨХӨӨРӨМЖ

- Дэлгүүрийн ажилчид эрүүл ахуйг сахин нэг удаагийн малгай өмсөж, маск зүүдэг.
- Хоолны үйлдвэрийн ажилчид үйлдвэрийн байранд орохдоо дундын гутал өмсөх бөгөөд үйлдвэрт орохдоо компаниас хангасан гутал (жилдээ 1 солидог), бүтэн биеийн хувцас (жилдээ 2 солидог) өмсөж, нэг удаагийн маск зүүж орно. Хүйтэн агуулахад (-18С-ийн) бараа шилжүүлж буй ажилчид компанийн хангасан куртка өмсдөг.
- Үйлдвэр, түгээлтийн төвийн хаалга, гарц бүхэн сенсортойгоос (1, зарим тохиолдолд 2) гадна гар ажиллагаагаар заавал хаагддаг учир хаалганд хавчуулах, хаалганд даруулах гэсэн тохиолдол гарах боломжгүй.

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Дэлгүүр бүр галын аюулгүй байдлыг хангах зорилгоор 2 гал унтраагуур, галын хөнжил, угаарын хий мэдрэгч сенсороор тоноглогдсон байх ба тэдгээрийн хугацааг тогтмол хяналтын хуудас хөтөлдөг байна.

Хүнсний үйлдвэр нь 100% автомат гал хамгааллын системтэй. Мөн газын байгууламж мэдрэгч сенсортой учир газ алдагдах тохиолдолд автоматаар хэрэглээг зогсоох, унтрах тохиргоотой.



ЭРХ ТЭГШ БАЙДАЛ



Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь одоогоор жендерийн эрх тэгш байдлын талаар ямар нэгэн бодлогын баримт бичиггүй байна. Гэвч хүйсээр ангилсан дата мэдээллийн бэлэн байдлаас харахад цаашид жендерийн дүн шинжилгээг хийж, түүнд үндэслэсэн Жендерийн эрх тэгш байдлыг бодлого/журмыг боловсруулж компанийнхэмжээнд нэвтрүүлэхэд бэлэн харагдаж буйг дурдах нь зүйтэй.

Жендерийн эрх тэгш байдлын бодлого гэдэгт зөвхөн эмэгтэйчүүдийг дэмжих тухай асуудлыг ойлгохгүй. Жендерийн эрх тэгш байдал гэж өөр өөр хүйсийн, өөр өөр гарал угсаа, шашин шүтлэг, хүйсийн чиг баримжаатай ялгаатай бүлгүүд эсвэл хувь хүмүүсийг нийгэм, соёл, эдийн засгийн хувьд хүлээн зөвшөөрч, хүлээн авч, тэдний эдлэх эрх, хүлээх үүрэг, олгогдсон боломжийг ижил тэгш хуваарилах хүчин чармайлтыг хэлнэ. Тэгш байдал гэдэг нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд адилхан болно гэсэн үг биш, харин эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн эрх үүрэг, боломж нь тухайн хүний хүйсээс үл хамааран ижил тэгш байх тухай ойлголт юм.

- Жендерийн дүн шинжилгээг компанийнхэмжээнд хийж гүйцэтгэн, түүнд үндэслэн цаашдын арга хэмжээг жендерийн мэдрэмжтэй байдлаар төлөвлөх
- Жендерийн бодлого, журмыг боловсруулж компанийнхэмжээнд мөрдүүлэн ажиллах

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

- Жендерийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх: Компанийнүйл ажиллагаа, бодлого шийдвэр, арга хэмжээний эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөллийг үнэлсний дүнд тухай бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх замаар тухайн үйл ажиллагааны үр өгөөжийг эмэгтэй, эрэгтэй хүмүүст ижил хүртээх, тэгш бус байдлыг таслан зогсоох, нийгмийн хэвшмэл ойлголтыг эвдэхэд хувь нэмэр оруулах. Жендерийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн эцсийн зорилго нь жендерийн эрх тэгш байдлыг хангах явдал юм.

Жендерийн бодлогыг боловсруулахдаа дараах хүрээнд боловсруулж, жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт хийх замаар жендерийн үзэл баримтлалыг ОУ-ын сайн жишгийн дагуу хэрэгжүүлж болно.

Дотоод үйл ажиллагаа
1

- Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах
- Ижил түвшинд ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын цалингийн зөрүүг арилгаж, ижил тэгш цалин урамшуулал олгох
- Мэдлэг, туршлага олж авах, карьерын болон хувь хүний хөгжлийн хувьд ахих боломжид эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын эзлэх хувийг тэнцүү байлгах
- Жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулах тухай мэдлэг олгох, чадавх бэхжүүлэх ажлуудыг нийт ажилтнуудад зохион байгуулдаг байх

Үйлчлүүлэгчид чиглэсэн
2

- Хэвшмэл ойлголтоос ангид, хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх
- Үйлчлүүлэгч үйлчилгээ авах явцдаа жендэрт суурилсан бүх төрлийн хүчирхийлэлд өртөхгүй байх орчин нөхцлийг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах бодлоготой байх
- Компани нь маркетингийн төрөл бүрийн суваг ашиглаж идэвхжүүлэлтийн үйл ажиллагаа явуулахдаа хүний эрхийг дээдэлсэн, жендэрийн мэдрэмжтэй мэдээлдэг байх

Нийгмийн нөлөөлөл
3

- Компани нь өөрийн жендэрийн бодлогын хүрээнд тодорхойлсон зарчмуудаа харилцагч байгууллагууд, ханган нийлүүлэгчдэд мөн ижил мөрдүүлж, хамтдаа жендэрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх
- Компани нь өөрийн жендэрийн эрх тэгш байдлын бодлого, арга хэмжээний талаар дуу хоолойгоо олон нийтэд нээлттэй хүргэж, бусад оролцогчдыг уриалан манлайлах
- Компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд жендэрийн эрх тэгш байдлыг түгээн дэлгэрүүлэх зорилготой төсөл, арга хэмжээнд өөрийн нөөц боломжоор дэмжлэг үзүүлэх

АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТЫН ЭСРЭГ БОДЛОГО, ЖУРАМ
S3.2
Тийм

Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?

Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫН ЭСРЭГ БОДЛОГО, ЖУРАМ
S3.3
Тийм

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь бүх төрлийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг үл тэвчдэг бөгөөд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээдийн хооронд үүсч болзошгүй бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэн, хариу арга хэмжээ авах тухай асуудлыг хөдөлмөрийн гэрээгээр зохицуулдаг.

ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, нийгмийн болон гэрлэлтийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, улс төрийн үзэл бодол, үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх, эрүүл мэндийн байдал, жирэмсэн болон амаржсан эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь шууд, эсхүл шууд бусаар ялгаварлан гадуурхах, эрхийг нь хязгаарлах, давуу байдал олгохыг хориглоно.

- Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биенээ үгээр, биеэр, цахимаар болон бусад аливаа хэлбэрээр сэтгэлзүйн болон бэлгийн дарамт үзүүлэх, хүчирхийлэл үйлдэх, заналхийлэх замаар ажлын байрны тэвчишгүй орчныг бий болгохыг хориглоно.

- Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ажил олгогч, ажилтан, гуравдагч этгээд бие биедээ хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үгээр, биеэр, цахимаар болон бусад хэлбэрээр илэрхийлэх, бэлгийн харилцаанд орох эсэхээс шалтгаалж ажил, албан тушаал, цалин хөлс зэрэг эдийн засгийн болон бусад байдлаар урамшуулах, эсхүл хохироохоор айлган сүрдүүлэх, тулган шаардах, болзол тавих байдлаар бэлгийн дарамт үзүүлэхийг хориглоно

- Ажилтан дээр дурдсанаар бүх төрлийн дарамт шахалт хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэх үйлдэл, эс үйлдэхүй гаргасан тохиолдолд хөдөлмөрийн гэрээг шууд цуцлах арга хэмжээ авна.

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

- Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үйлдсэн этгээдэд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх бөгөөд ийнхүү хариуцлага хүлээлгэсэн нь хөдөлмөрийн сахилгын шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй

- Одоогийн түвшинд бэлгийн дарамтын эсрэг хариу арга хэмжээ авах байдлыг хөдөлмөрийн гэрээний хүрээнд зохицуулж байгаа хэдий ч үйлчлүүлэгч ажилтанд бэлгийн дарамт болон бусад үг хэлээр, биеээр хүчирхийлэл, доромжлол үзүүлсэн тохиолдолд шүгэл үлээх, хохирогчийг хамгаалах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа нь тодорхой биш байна.


САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

- Иймээс, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тусгайлсан бодлого/журамтай болох, ингэснээр эрсдэлийг илүү өргөн хүрээнд тодорхойлж, түүнийг дагалдсан ажилтан, ажил олгогч, гуравдагч этгээдийг эрсдэлээс хамгаалах, гомдлыг аюулгүй хүлээн авах, хохирогчийг хамгаалах арга хэмжээг тодорхойлох боломжтой болно. Мөн бодлогын цар хүрээ, хэрэгжих үйл явцыг нийт ажилтнуудад сургалтаар танилцуулах.
- Бүх төрлийн хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалттай холбоотойгоор үйлчлүүлэгчээс болон ажилтнуудаас ирсэн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах шугамтай болох, тэдгээрийг гомдол гаргагчийн эрх ашгийг хамгаалахуйц тохирох албан тушаалтнаар бүртгүүлж, тоог бүртгэх, холбогдох шийдвэр гаргагчдад мэдээлэх, цаашдын бодлогын арга хэмжээ авах тогтолцоо бүрдүүлэх. Хэмжиж чадвал анхааралдаа авна, арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.


Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-н нийт ажилтнууд ба дунд ба анхан шатны нэгжийн ажилтнуудад эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзлэж байна. Харин ТУЗ-д эмэгтэйчүүдийн төлөөлөл 0 хувь, Гүйцэтгэх удирдлагын багт эмэгтэйчүүд 73 хувийг эзлэж байна. Жендэрт суурилсан цалин хөлсний зөрүүг харвал эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 1.14 дахин өндөр цалин хөлс авч байна.

		Сэнтрал Экспресс ХК	Сэнтрал Фүүдс ХХК
S3.4: Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	эрэгтэй-34% эмэгтэй-66%	эрэгтэй-20%, эмэгтэй 80%
S3.5: Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	эрэгтэй-100%	n/a
S3.6: Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	эрэгтэй-27% эмэгтэй-73%	эрэгтэй-75%, эмэгтэй-25%
S3.7: Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	эрэгтэй-37% эмэгтэй-63%	эрэгтэй-39%, эмэгтэй-61%
S3.8: Жендэрт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	эмэгтэй/ Эрэгтэй=1.14	Эмэгтэй/ Эрэгтэй=1.22

Ажилтнуудын хүйсийн харьцаа, албан тушаалаар



Цалин, урамшуулал хүйсээр



БОНЗ-ын тайлагналын удирдамжид дурдсан индикаторуудаас гадна ажилтнууддаа олгож буй хувь хүний хөгжил болон манлайлах боломжуудаар хангаж буй байдал, жендэрийн талаарх мэдлэг ойлголт түгээж буй байдал, ханган нийлүүлэгчидээ жендэрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд уриалж буй байдал зэргийг нэмэлтээр шинжилсэнийг доор харуулав.

Манлайллын хөтөлбөрийн хүртээмж, хүйсээр	эрэгтэй	эмэгтэй	нийт	эмэгтэй %	эрэгтэй %
Дунд түвшний захирлын албан тушаалд ажиллагсадаас сүүлийн 12 сард манлайлал, удирдлагын сургалт, хөтөлбөрт хамрагдсан нийт ажилтнуудын тоо	5	7	12	58.33%	41.67%
Менежерийн албан тушаалд ажиллагсадаас сүүлийн 12 сард манлайлал, удирдлагын сургалт, хөтөлбөрт хамрагдсан нийт ажилтнуудын тоо	5	16	21	76.19%	23.81%
Манлайлал, удирдлагын сургалт, хөтөлбөрт хамрагдсан бүх албан тушаалын, нийт ажилтнуудын тоо	0	6	6	100.00%	0.00%
Нийт	10	29	39	74.36%	25.64%

Жендэртэй хамааралтай сургалт	эрэгтэй	эмэгтэй	нийт	эмэгтэй %	эрэгтэй %
Дунд түвшний захирлын албан тушаалд ажиллагсадаас сүүлийн 12 сард жендэртэй холбоотой сургалт, хөтөлбөрт хамрагдсан нийт ажилтнуудын тоо	0	0	0	0%	0.00%
Менежерийн албан тушаалд ажиллагсадаас сүүлийн 12 сард жендэртэй холбоотой сургалт, хөтөлбөрт хамрагдсан нийт ажилтнуудын тоо	0	1	1	100%	0.00%
Фронт оффисын ажилтнуудаас сүүлийн 12 сард жендэртэй холбоотой сургалт, хөтөлбөрт хамрагдсан нийт ажилтнуудын тоо	0	0	0	0%	0.00%
Жендэртэй холбоото сургалт, хөтөлбөрт хамрагдсан бүх албан тушаалын, нийт ажилтнуудын тоо	0	0	0	0%	0.00%
Нийт	0	1	1	100%	0.00%

Ханган нийлүүлэгчид, хамтрагч байгууллагууд	эрэгтэй	эмэгтэй	нийт	эмэгтэй %	эрэгтэй %
Сүүлийн 12 сард хамтран ажилласан нийт ханган нийлүүлэгчд (бизнесийн түншүүд)-ийн тоо	n/a	n/a	453	n/a	n/a

Жендэрийн үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлж буй байдал (mainstreaming)	тоо
Сүүлийн 12 сард танай байгууллагын жендэрийн эрх тэгш байдлын бодлого, үүрэг амлалтын талаар хэвлэл мэдээлэлд дурдагдсан нийт тоо*	2
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дэмжлэгийн тоо	n/a
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дэмжлэгийн мөнгөн дүн	n/a
Жендэрийн эрх тэгш байдлын талаар олон нийтэд танилцуулах, яриа хийх боломж олдсон тоо	n/a

Дээрх хүйсээр ангилсан дүн шинжилгээнээс харахад Компани нь эмэгтэй ажилтнуудыг удирдах, манлайлах чиглэлд сурч хөгжих боломжоор хангадаг бөгөөд нийт манлайллын сургалтын үр ашиг хүртэгчдийн 74.36 хувь нь эмэгтэй ажилтнууд байна.

Харин жендэрийн сургалт, мэдээлэл авсан зөвхөн 1 менежерийн түвшний ажилтан байгаа бөгөөд ханган нийлүүлэгчдийн бүртгэлийг хүйсээр ангилдаг практик одоогоор байхгүй байна. Компани нь сүүлийн 12 сарын хугацаанд 2 удаагийн жендэрийн эрх тэгш байдал, хүртээмжтэй, олон талт байдалтай аолбоотой мэдээллийг олон нийтэд түгээжээ.

- Шийдвэр гаргах буюу удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийг төлөөллийг 40 хувиас багагүй байхаар тодорхойлох.

- Менежер, дэлгүүрийн менежер албан тушаал дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалингийн зөрүүг багасгах, цаашид ижил тэгш цалин хөлс олгодог байх.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

- Жендэрийн бодлого батлагдсаны дараа нийт ажилтнуудад жендэрийн эрх тэгш байдлын талаар сургалт зохион байгуулах, энэ чиглэлд чадавх бэхжүүлэх ажлууддыг дотооддоо өрнүүлэх.

- Компанийнжендэрийн эрх тэгш байдлыг хангах, хүртээмжтэй, олон талт байдлыг бий болгох чиглэлд авч хэрэгжүүлж арга хэмжээний талаар нийт ханган нийлүүлэгч, оролцогч талуудад нээлттэй танилцуулж, мөн ижил шаардлагыг тавьж ажиллах.

- Хамтран ажиллагч түнш байгууллагууд, ханган нийлүүлэгчдийн мэдээллийг цаашид хүйсээр ангилан бүртгэж байх. Ингэснээр цаашид жендэрийн мэдрэмжтэй шийдвэр гаргах суурь нөхцөл бүрдэнэ.

- Компани нь Жендэрийн бодлогоо баталсны үндсэн дээр нийгэмд нөлөөлөхүйц олон нийтийн арга хэмжээ, мэдэгдэл хийх, аливаа уулзалт арга хэмжээнд компанийнжендэрийн эрх тэгш байдлын төлөөх үүрэг амлалтын талаар мэдээлж, салбарын бусад оролцогчдыг уриалж, үлгэрлэх, цаашлаад энэ чиглэлт төсөл, хөтөлбөр, санаачилгыг өөрийн нөөц боломжийн хүрээнд дэмжиж хамтарч ажиллах.

ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ




Хүний нөөцийн хүртээмжтэй байдал

Компани нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин үүсгэн байгуулагдсан үеэс хойш СУ дэлгүүрүүдэд ажлын байрыг хуулийн квотын дагуу биелүүлсээр ирсэн. Ханган нийлүүлэгч үйлдвэрүүд ч үүнийг үлгэрлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангадаг жишиг тогтжээ.

2022 оны хувьд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ажилчид болон Сэнтрал Фүүдс ХХК-ийн ажилчдын нийт 4% нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байсан байна. Дэлгүүрүүдэд саажилттай, сонсголын бэрхшээлтэй зэрэг хүмүүс ажиллах нь элбэг. Зарим хүнсний үйлдвэрүүдэд тэргэнцэртэй хүмүүс ч ажиллах боломжтой, ажиллаж байсан түүх бий. Хамтран ажиллагсад, удирдлагуудын уур амьсгал, сэтгэгдлийг сонсоход хөгжлийн бэрхшээлтэй ажилчид нь ихэвчлэн үүргээ давуулан биелүүлдэг, шаргуу хүмүүс байдаг учир ялгаварлан гадуурхах, ажиллах боломжгүй гэх мэт нөхцөл үүсдэггүй. Тухайн хүний бэрхшээлээс хамааран цэвэрлэгчээс гадна касс бичилт, бараа өрөлт, тооллого, хоол бэлтгэлийн хэсэгт ажиллах гээд олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг. Харин хөдөлмөрийн журамд 7 хоногийн 40 цагийн шаардлага ижил хамаардаггүй.

ХБИ ажилтанд бий болгосон ажлын байр, хүн цагаар



Үүнээс гадна хүнсний үйлдвэрийн ажилтнуудын хувьд Хонхорт байрлах учир хүний нөөцийнхөө 50%-с дээш хувийг ойролцоох Налайх дүүргээс бүрдүүлсэн бөгөөд үүний тал орчим нь Казах иргэд байдаг. Монгол хэлээр ярьдаггүй ажилчдын тохиолдолд Монгол хэлтэй Казах ажилчинтай бадди системээр ажиллуулдаг бөгөөд Казах уламжлалт тэмдэглэлт баяр, зан заншлыг хүндэтгэн авч үздэг.

Тэргэнцэрт зориулсан налуу зам: СУ дэлгүүрүүдийн хувьд объектуудаа түрээсэлдэг учир тэргэнцэртэй иргэн орох боломжийг хангасан налуу замгүй объектууд байх тохиолдлууд байна. Налуу замтай ч бариул хэт хол байрласан, хэт эгц өндөр гэхчилэн стандартын дагуу баригдаагүй байх нь элбэг.


БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Үйлдвэрийн объектуудын хувьд мөн адил, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн нь хомс тул зарим үйлдвэрлэгчдийн хувьд үйлдвэрийн байраа солиход хөгжлийн бэрхшээлтэй ажилчин нь ажиллах боломжгүй болсон зэрэг тохиолдол гардаг.


SU дэлгүүрээр үйлчлүүлж буй сая хүн дараах үйлчилгээг ямар нэг худалдан авалт хийх нөхцөлгүйгээр санал болгож, нийслэл болон салбар дэлгүүр байршиж буй орон нутгийн хоол үйлчилгээний соёл, стандартыг өөр түвшинд авчиргаад 4 жил болжээ.

ХОТ СУУРИН ГАЗРЫГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Ариун цэврийн газар: Нийслэлд олон нийтийн ариун цэврийн байгууламжийг дангаар шийдэж өгсөн нь нийслэлийн иргэдийг ая тохитой амьдрах, олон жилийн турш гаргалгаа олдоогүй асуудлын шийдлийг бий болгосон хэрэг юм.
- Гадна талбайн цэвэрлэгээ: SU дэлгүүрүүд гадаад орчны 50м талбайгаа тохижуулсан гэрэлтүүлэгтэй, хальтиргаа гулгаанаас хамгаалж цэвэрлэсэн байх шаардлага тавьдаг.
- 24 цагийн камержуулалт: 1 сарын хугацаатай хадгалагддаг камерийн бичлэг хийгддэг бөгөөд хүмүүс юмаа мартаж орхих, хулгай, гэмт хэрэгт өртөх гэх мэт тохиолдлуудад холбогдох байгууллагын зөвшөөрлөөр бичлэг шүүж нотолгоо болсон тохиолдлууд бий.
- Үнэгүй Wi-Fi цэг: Хотын төв гэлтгүй захын бүсүүдэд кофе шоптой адил үйлчилгээ үзүүлэх ач холбогдолтой юм.
- Шуудангийн үйлчилгээ: Stora хүргэлтийн цэгүүд тодорхой цэгүүдэд байрласан. Мөн төрийн үйлчилгээний киоск цэгүүдийг байрлуулахаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- Хүргэлтийн үйлчилгээ: Ковид-19 цар тахлын үед хүргэлтийн үйлчилгээг хэрэгжүүлж байсан нь өндөрлөсөн бөгөөд цар тахлын үед ч мөн зогсолтгүй хэрэглэгчдэдээ ойр байх зарчмыг баримтлан хэрэглэгчид хамгийн ойрын салбараасаа хамгийн хурднаар хүргэлтийг авах боломжтой байснаараа онцлог.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА, ИЛ ТОД БАЙДАЛ



Компани нь оролцогч талууд, коммюнити-тэй ажиллах тусгайлсан бодлого, журам батлаагүй хэдий ч компанийннийгмийн хариуцлагын хүрээнд аль хэдийн оролцогч талуудын хамтарсан оролцоог хангасан ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

МУ-ын нийгэм, эдийн засаг, жижиг дунд худалдаа үйлчилгээ эрхлэх салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг бий болгох, хотын соёлыг хөгжүүлэх, худалдаа үйлчилгээний салбарын хөгжлийн өнөө ба ирээдүй үеийн хэрэгцээ шаардлагыг хангаж ажиллах зорилгын дор хамтын ажиллагааны санамж бичгийг 2022 оны 10 сарын 13-ны өдөр байгуулсан. Талууд нь дараах чиглэлд хамран ажиллаж байна. Үүнд:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Нийслэлийн хүн амыг эрүүл хүнсээр хангах
- Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх
- Ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Гарааны бизнесийг дэмжих
- Байгаль орчин, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Дархан сумын иргэдэд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт ажил хөдөлмөр эрхлэхэд шаардагдах, бизнес эрхлэгчдийн шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх, зорилтот бүлгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, “Ногоон Дархан” хөтөлбөрт хамтран ажиллах санамж бичгийг 2022 оны 11 сарын 24-ний өдөр байгуулан ажиллаж байна.


“СУ ЧАМД ТУСАЛЪЯ” ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР

Нийслэлийн цагдаагийн ерөнхий газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх газартай хамтран хэрэгжүүлж байгаа “СУ ЧАМД ТУСАЛЪЯ” хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хүрээнд эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрч, тусламж эрсэн 7 хүүхдийг цагдаагийн байгууллагаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагчид нь аюулгүй хүлээлгэн өгсөн.

Уг төслийн зорилго нь бага насны хүүхдийг төөрөхөөс сэргийлэх, төөрсөн хүүхдийг аюулгүй байлгах, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх бөгөөд СУ брэнд Улаанбаатар хот дах 285 гаруй салбар дэлгүүрээр дамжуулан тусламж үзүүлэх, дэлгүүрийн дотоод мэдээллийн сүлжээгээр дамжуулан бүх салбарт төөрсөн хүүхдийн мэдээллийг хүргэх, харьяа дүүргийн цагдаагийн газартай шуурхай холбогдож мэдээллийг хүргүүлэн, хүүхдийг гэр бүлд нь аюулгүй хүлээлгэн өгөхөд оршиж байна.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ


Цаашид оролцогч талуудаа бүлэгт ангилан тодорхойлох, оролцогч тал тус бүрт компанийн үйл ажиллагааны үзүүлэх нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр оролцогч талуудын эрх ашигийг хөндөхгүй хамтран ажиллах тухай “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах” тусгайлсан бодлого, журам эсвэл хөтөлбөртэй болж компанийн дээд удирдлагаар батлуулах, батлагдсан бодлогын баримт бичгийн талаар нийт оролцогч талуудад тэгш мэдээлэл хүргэж ажиллах.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-д одоогоор нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журам байхгүй байна.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Цаашид “Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого”-н хүрээнд БОНЗ-ын нөлөөллийн үнэлгээг хийлгэж, түүнд үндэслэсэн нийгмийн нөлөөллийн бодлого боловсруулах, дээд удирдлагаар батлуулах.



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-н “Үйлчлүүлэгчин санал, гомдлыг шийдвэрлэх журам” нь 2022 оны 6 сарын 20-ны өдрийн Гүйцэтгэх захирлын тушаалаар, Сэнтрал Фүүдс ХХК-н “Хэрэглэгчийн санал, гомдлыг шийдвэрлэх журам” нь Гүйцэтгэх захирлын 2022 оны 11 сарын 15-ны өдрийн тушаалаар тус тус батлагдсан.

Журмын хүрээнд үйлчлүүлэгчээс ирж буй гомдлыг ноцтой, ноцтой биш гэсэн 2 төрөлд ангилах бөгөөд дараах сувгуудаар хүлээн авдаг. Дуудлага хяналтын төв бүх сувгаар ирсэн гомдол, саналыг хүлээн авч нэгдсэн бүртгэл үүсгэх бөгөөд үйлчлүүлэгчийн санал, гомдлын мөрөөр анхан шатны мөшгөлт хийж, гомдол гаргагчтай холбогдож, гомдлын дүгнэлт гаргаснаар гомдлыг хаадаг.

Ноцтой гомдол	Ноцтой биш гомдол	Гомдол хүлээн авах суваг
Хоолны хордлого	Амт үзэмж муу	Дуудлага хяналтын төв 77330101 дугаар
Бүтээгдэхүүнээс гадны биет илэрсэн	Үйлчилгээнд бэлэн бус	Имэйл: callcenter@cumongol.mn
Хугацаа дууссан бүтээгдэхүүн худалдсан, бүтээгдэхүүн муудсан	Хүргэлтийн үйлчилгээ	CU App
Ажилтны бүдүүлэг харилцаа	Цэвэрлэгээ /үйлчилгээний тав тух/	Сошиал хуудас: Facebook, Instagram хуудсууд дахь чатбот
Ажилтан, үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан	CU App-тай холбоотой	Үйлчлүүлэгч салбар дэлгүүрт биечлэн гаргах
	Бусад	

2022 оны байдлаар ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг 100 хувь шийдвэрлэсэн байна.

#	Ангилал	Гомдлын тоо	Санал хүсэлтийн тоо	Гомдол эзлэх хувь	Санал хүсэлт эзлэх хувь
ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ.	CUAPP-тай холбоотой	12		1.0%	0.0%
	Ажилтан, үйлчлүүлэгчийн эрүүл мэнд хохирсон	9		0.7%	0.0%
	Ажилтны харилцаа	114	14	9.4%	23.3%
	Амт үзэмж муу	242	18	19.9%	30.0%
	Ар гэрийн гомдол	12		1.0%	0.0%
	Бусад	37	3	3.0%	5.0%
	Бүтээгдэхүүн муудсан, чанар алдагдсан	241	1	19.8%	1.7%
	Бүтээгдэхүүн тасалдал	1	1	0.1%	1.7%
	Бүтээгдэхүүний хадгалах хугацаа дууссан	16		1.3%	0.0%
	Гадны биет илэрсэн	303	1	24.9%	1.7%
	Сав баглаа боодол гэмтэлтэй	2		0.2%	0.0%
	Түгээлтийн жолоочийн харилцаа	5		0.4%	0.0%
	Үйлчилгээнд бэлэн бус	58	18	4.8%	30.0%
	Хадгалалтын горим алдагдсан	2		0.2%	0.0%
	Харшил	1		0.1%	0.0%
	Хаяг шошго, сав баглаа боодол гэмтэлтэй	9	1	0.7%	1.7%
	Хордлого	105		8.6%	0.0%
	Хүргэлтийн үйлчилгээ	36	1	3.0%	1.7%
	Цэвэрлэгээ /үйлчилгээний тав тух/	12	2	1.0%	3.3%
	Нийт		1217	60	100%

S5.6

НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГЫН
ҮЙЛ
АЖИЛЛАГААНД
ЗАРЦУУЛСАН
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ

n/a


Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-оор ангилсан

Энэ чиглэлд оруулсан хөрөнгө оруулалтыг ангилан харуулсан тоо баримт бэлэн байхгүй байна.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ


Цаашид Нийгмийн хариуцлагын хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг ТХЗ-д оруулж буй хувь нэмрээр ангилан бүртгэх, нийт орлого ба зардалд эзлэх хувийг тооцоолж, тайлан мэдээлэлд тусгаж занших.

ТОГТВОРТОЙ ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ



Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?

Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь



Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь

Компани ханган нийлүүлэгчидтэй хийх гэрээ, ханган нийлүүлэгчдэд тавих шаардлага гэсэн баримт бичгүүдийн хүрээнд эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны бүхий л гарч болох асуудлуудыг тусгасан бөгөөд өртгийн сүлжээг байгаль орчинд ээлтэй болгох зөвлөмж, шаардлагуудыг эдгээр баримт бичигт тусгах боломжтой. Тухайлбал ханган нийлүүлэгчидтэй хийх гэрээндээ хүүхдийн хүнд хөдөлмөр эрхлэхгүй байх шаардлагыг тусгасан бөгөөд гэрээний хавсралтаар Гэрээт болон туслан гүйцэтгэгч нарын дагаж мөрдөх ХАБЭА, БО-ны журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээлгэдэг. Түүнийгээ Гүйцэтгэх захирлын А-21/06 тушаалаар батлагдсан Нийлүүлэгчид үнэлгээ хийх журмын дагуу хянах тогтолцоотой. Мөн "ханган нийлүүлэгч, гэрээт компаниудад тавих шаардлага"-д байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хэмжиж, хяналт тавих шаардлага тавидаг. Ханган нийлүүлэгчийн хяналтын журам мөн Бэлтгэн нийлүүлэгчийн хяналтын журамтай. Мөн Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, нийлүүлэлтийн гинжин хэлхээний хяналт, удирдамжийг батлахаар ажиллаж байна.

Мөн Сэнтрал Экспресс Си Ви Эс-ийн нийт худалдан авалтын 91%, Сэнтрал Фүүдс компанийн 90% нь дотоодын ханган нийлүүлэгчид эзэлж байгаа. Ингэснээр дотооддоо 53.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн урсгалыг бий болгосон бөгөөд шууд бус буюу ханган нийлүүлэгчдийн төлсөн татвар ойролцоогоор 5 тэрбум гэж тооцож болох юм. Түүнчлэн компани өсөн дэвжихийн хэрээр ханган нийлүүлж буй хоол үйлдвэрлэгчид мөн цар хүрээгээ тэлж, шинээр тогтвортой ажлын байр бий болгох, цаашлаад улсад төлөх татварын хэмжээг нэмэгдүүлэхэд их хувь нэмэр оруулж байна.

SU дэлгүүр нь нийт 17 хоол үйлдвэрлэгч Монгол бизнестэй хамтран ажилладаг. Тайланг гаргах зорилгоор 3 ханган нийлүүлэгчээс ярилцлага авахад SU-тэй гэрээлснээс хойш дараах байдлаар шинэ ажлын байр нэмэгдүүлж, орлого, татварын хэмжээг ихэсгэсэн байна.

ШУУД БУС АЖЛЫН БАЙР: ХООЛ ҮЙЛДВЭРЛЭГЧИД

- Нийлүүлэгч 5 ажилтнаас 30 хүнтэй болж өссөн,
- 4 ажилчнаас 35 ажилчинтай болсон,
- 4 ажилчнаас 15 ажилчидтай болсон.

Ханган нийлүүлэгчдийн нөөцийн удирдлага, үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарыг сайжруулах зорилгоор “Хамтдаа хөгжье” 2 шаттай хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт 12 үйлдвэрийг хамрууллаа. Хөтөлбөрийн дүнг хэмжин, цаашид сайжруулах зөвлөмжийг мөн сургагч, стандартыг нэвтрүүлж буй зөвлөх үйлчилгээний компаниас гаргаж өгсөн нь их үр дүнтэй байсныг хоол үйлдвэрлэгч ханган нийлүүлэгчид ярилцлагыг үед хэлж байсан юм.

SU дэлгүүр нь нийт 17 хоол үйлдвэрлэгч Монгол бизнестэй хамтран ажилладаг бөгөөд түүнээс эхний ээлжний 12 үйлдвэрийг сонгон дараах 2 шаттай сургаалтыг орсон. Үүнд:

ХАМТДАА ХӨГЖЬЕ: ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ


- 1) Хүнсний чанар, аюулгүй байдлын сургалт
- 2) НАССР гэрчилгээжүүлэх сургалт

Сургалтын үр дүнд зохистой дадлын сургалтыг үйлдвэрийн дарга, техникчийн түвшинд авса, бичиг баримтын бүрдлийг сайжруулсан, дотоод хяналтын тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн, ажилчдын эрүүл ахуй, ариун цэврийн дадал сайжирсан, үйлдвэрийн давхцалыг арилгасан, үйлдвэрийн байрыг сайжруулсан, ажилчдын идэвх чармайлт нэмэгдсэн гэх мэт маш олон төрлийн үзүүлэлтээр ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаа сайжирсан байна.

САЙЖРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

Цаашид ханган нийлүүлэгчдийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, мэдээллийг бүртгэл, мэдээллээр авч, хянадаг болох, түүнийг БОНЗ-ын тайландаа тусгах.

Худалдан авалтын бодлогод уур амьсгалын эрсдэлд хамгийн их өртөх эрсдэлтэй үйл ажиллагаануудыг дэмжих хөрөнгө оруулалт, худалдан авалтад анхаарах талаар журамд тусгах.



Бүлэг

4

ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

Компанийн засаглал
Авилга ба ёс зүй
Комплайнс




КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ



Шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-н засаглалын бүтэц нь МУ-ын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох дүрэм, журамд нийцсэн, үндсэн үйл ажиллагааны чиглэл стратегийг тодорхойлох, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Компани нь Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ноос баталсан Компанийн засаглалын кодекс болон ОУ-д танигдсан шилдэг туршлага, зарчмуудыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн компанийн дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг Компанийн засаглалын кодексийн зарчимд нийцүүлэн баталгаажуулах, дагаж мөрдөж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвшил болгох зорилгоор “Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийг батлуулах чиглэлд ажиллаж байна.



- Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах
- ТУЗ болон Гүйцэтгэх захирлын хариуцлагын тогтолцоог ОУ-ын жишигт хүргэх
- Тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах
- Эрсдэлийн удирдлагыг сайжруулах
- Хяналтын тогтолцоог сайжруулах



- Холбогдох хууль, дүрэм журамд тусгагдсан бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн мөрдүүлэх
- Компанийн бодлогын баримт бичиг, дүрэм журам, зааврын хэрэгжилтэд комплайнсын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх
- Эрх бүхий албан тушаалтанг компанийн засаглалын сургалтад хамруулах
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах мэдээлэх



ТУЗ нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлж, хяналт тавин ажилладаг. ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд эдгээр гишүүдийн 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүд юм.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төрөл	Овог нэр	Хүйс	Албан тушаал	Томилогдсон огноо	Мэргэжил, боловсрол, ажлын туршлага
ТУЗ-ийн гишүүн	А.Ганхуяг	Эр	ТУЗ-ийн дарга	10/31/2019	Адилбишийн Ганхуяг нь Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, Премиум Групп ХХК болон Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн дарга, Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгч бөгөөд сүүлийн 20 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (НКЕХ: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгээр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургуулийг санхүү, эдийн засгийн бакалаврын зэрэгтэй төгссөн.
ТУЗ-ийн гишүүн	Г.Чинзориг	Эр	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	10/31/2019	Ганболдын Чинзориг нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал юм. Тэрээр программ хангамж, бизнес процесс, бизнес интележенс, мэдээллийн технологийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газар ("МТШХХГ")-ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагт Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба өрсөлдөх чадварын төслийн мэдээллийн технологийн зөвлөх, Азийн Хөгжлийн Банкны Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл, Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба санхүүгийн дэд бүтцийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр МТШХХГ-д ажиллаж байхдаа Цахим засаглал хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбоо, интернэт, шуудан, хэвлэл мэдээлэл, хиймэл дагуулын холбооны талаар баримтлах төрийн бодлого болон Мобайл сүлжээний 4G үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зохицуулалтын бодлогыг боловсруулсан. Г.Чинзориг нь ШУТИС-ийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Луисвиллийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

Төрөл	Овог нэр	Хүйс	Албан тушаал	Томилогдсон огноо	Мэргэжил, боловсрол, ажлын туршлага
ТУЗ-ийн гишүүн	А.Ганболд	Эр	ТУЗ-ийн гишүүн	10/31/2019	Адилбишийн Ганболд нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, Премиум Групп ХХК-ийн охин, хараат компаниудын үйл ажиллагааг удирдан, стратегийн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бүтцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Түүний барилгын салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан юм. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль ("ШУТИС")-ийг цахилгаан тээвэр, системийн инженер мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй.
ТУЗ-ийн гишүүн	Г.Бат-Эрдэнэ	Эр	ТУЗ-ийн гишүүн	10/31/2019	Гансүхийн Бат-Эрдэнэ нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Групп ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч бөгөөд тус группийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хариуцан ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 18 жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпораци (НКЕХ:975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.
ТУЗ-ийн гишүүн	О.Батмөнх	Эр	ТУЗ-ийн гишүүн	10/31/2019	Очирбатын Батмөнх нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Групп ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Дэд ерөнхийлөгч, Премиум Конкрит ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд тус группийн уул уурхай, барилга, бетон зуурмагийн бизнесийг хариуцан ажилладаг. Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал (NUBIA), Шангри-Ла зочид буудал цогцолбор төсөл, Салхит (50 МВт), Сайншанд (55 МВт), Цогтцэций (50 МВт) зэрэг салхин цахилгаан станцын төслүүд, Оюу толгой Бетон зуурмагийн 4 дүгээр үйлдвэрийн цогцолбор болон бутлуурын үйлдвэрүүдийн зураг төсөл, барилга, үйл ажиллагааг хариуцах зэргээр томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн, бизнесийн удирдлагын чиглэлээр 15 жил ажилласан туршлагатай. Тэрээр АНУ-ын Үндэсний Их Сургуулийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр төгссөн.

Төрөл	Овог нэр	Хүйс	Албан тушаал	Томилогдсон огноо	Мэргэжил, боловсрол, ажлын туршлага
ТУЗ-ийн гишүүн	Б.Бат-Эрдэнэ	Эр	ТУЗ-ийн гишүүн	12/28/2021	Болдбаатарын Бат-Эрдэнэ нь Сэнтрал Экпресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Польшийн Хөгжлийн Сангийн Хөрөнгө Оруулалт Худалдааны Агентлагийн Монгол дахь суурин төлөөлөгч, Хорайзон Партнерс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, худалдааны чиглэлээр 12 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Польш, АНУ, Швейцар улсад сурч, Монголын анхны гадаадын (Японы) хөрөнгө оруулалтын банканд зах зээлийн шинжээчээр, Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалттай Монголын анхны хаалттай хөрөнгө оруулалтын санд (50 сая ам. долларын) зах зээл, бизнесийн шинжээчээр, Польш-Монголын хамтарсан худалдааны компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан ба Азийн Хөгжлийн Банкны Монгол улсад "Private Equity" болон "Venture Capital" хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компаниар ажилласан хөрөнгө оруулалт, стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээний компанийн үүсгэн байгуулагч юм. Б.Бат-Эрдэнэ нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Н.Энхболд	Эр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	1/28/2022	Нямжавын Энхболд нь Сэнтрал Экпресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд 2016 оноос Ньюком Группийн Гүйцэтгэх захирлаар, 2017 оноос 2022 оныг хүртэл ТУЗ-ийн даргаар ажиллаж тус группийн өсөлтийг тасралтгүй хангах, үнэ цэнийг бий болгохын тулд гүйцэтгэх удирдлагын багтай хамтран ажилласан. Тэрээр хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлага, санхүү, төсөл боловсруулалт, корпорацийн стратеги, бизнес хөгжил, үйл ажиллагаа зэрэг Ньюкомын бүхий л салбар нэгжид идэвхтэй үүрэг гүйцэтгэн ажилласан бөгөөд тус группийн хөрөнгө оруулалттай компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар мөн ажиллаж байсан. Тэрээр өмнө нь М-Си-Эс Группийн стратеги, бизнес хөгжил хариуцсан дэд захирал, группийн бусад компаниудад гүйцэтгэх удирдлагаар 17 жил ажиллахдаа мэдээллийн технологи, харилцаа холбоо, санхүү, үл хөдлөх хөрөнгө зэрэг олон салбарт ажилласан туршлагатай бөгөөд 2013 онд төрийн дээд шагнал Алтан гадас одонгоор шагнуулсан. Н.Энхболд нь Нидерландын Маастрихтын Удирдлагын Сургуулийг корпорацийн стратеги, бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй, МУИС-ийг электроникийн инженер, бакалаврын зэрэгтэй төгссөн.

Төрөл	Овог нэр	Хүйс	Албан тушаал	Томилогдсон огноо	Мэргэжил, боловсрол, ажлын туршлага
ТУЗ-ийн хараат бус гишүүн	В.Ганзориг	Эр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	6/10/2022	Ванчигийн Ганзориг нь стратеги ба коммуникацийн чиглэлээр мэргэшсэн Бат Солюшн Партнерс ХХК-ийн Удирдах зөвлөлийн дарга, "CEO" клубийн ерөнхийлөгч, Монголын Дауны Холбоо, Менторшипийн залуу мэргэжилтнүүдийн хөтөлбөрийн тэргүүн, Монголын Тусгай Олимпын Хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, "Global Teacher Prize"-ийн академийн гишүүн, Синдикат ярилцлага нэвтрүүлгийн модератор, тэргүүлэх мэдээллийн сайтуудын нийтлэлчээр ажилладаг. Тэрээр Худалдаа Хөгжлийн Банк, ХасБанк, МОСДАК, Шунхлай Группийн удирдлагын багт ажиллаж байсан туршлагатай бөгөөд Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2014 оны дэлхийн залуу манлайлагчаар шалгарсан. В.Ганзориг нь Японы Олон Улсын Их Сургуулийг цахим бизнесийн удирдлагын магистр, Австралийн Нотре Даме Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд АНУ (Virginia, Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS, Cape Town), Сингапур (NUS) улсуудад удирдлага, манлайлал, бодлогын инновац, гео улс төр, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан Монголын Улсын мэргэшсэн зөвлөх юм.
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Гари Биондо	Эр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	12/28/2021	Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Улаанбаатар дахь Олон Улсын Дунд Сургуулийн ТУЗ-ийн дарга, Жуулчин Уорлд Турс ХХК-ийн ахлах зөвлөх, Эдельвайс Арт зочид буудлын гүйцэтгэх захирал бөгөөд Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол)-ын ТУЗ-ийн дэд даргаар ажиллаж байсан. Тэрээр 30 гаруй жил зочид буудлын менежментийн салбарт, тэр дундаа ажилчдын сургалтын хөтөлбөр, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, чанар, дотоод хяналтын удирдлага, галын аюул, осол үүсэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан туршлагатай. Гари Биондо нь Азийн өөр өөр соёл иргэншилтэй олон улс орнуудад өндөр зэрэглэлийн Шангри-Ла олон улсын зочид буудал, резортод 28 жил ерөнхий менежер, гүйцэтгэх удирдлагаар ажилласан бөгөөд АНУ-ын Колорадо мужийн Колорадо Коллежийг сонгодог уран зохиол, гүн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД:

№	ТУЗ-ийн хорооны нэр	Гишүүдийн нэр	Албан түшаал	Томилогдсон огноо
1	Байгаль орчин, нийгэм засаглалын хороо	Гари Биондо	Хороон дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн	12/28/2021
		О.Батмөнх	ТУЗ-ийн ердийн гишүүн	10/31/2019
		Б.Бат-Эрдэнэ	ТУЗ-ийн ердийн гишүүн	12/28/2021
2	Нэр дэвшүүлэх хороо	А.Ганхуяг	ТУЗ-ийн дарга	10/31/2019
		Н.Энхболд	Хороон дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн	1/28/2022
		В.Ганзориг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	6/10/2022
3	Цалин урамшууллын хороо	А.Ганболд	ТУЗ-ийн ердийн гишүүн	10/31/2019
		Н.Энхболд	ТУЗ-ийн хараат бус гишүүн	1/28/2022
		Гари Биондо	Хороон дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн	12/28/2021
4	Аудитийн хороо	Г.Бат-Эрдэнэ	ТУЗ-ийн ердийн гишүүн	10/31/2019
		В.Ганзориг	Хороон дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн	6/10/2022
		Гари Биондо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	12/28/2021

ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

	хэмжих нэгж	2020	2021	2022
ТУЗ-ийн хурал зохион байгуулагдсан тоо	удаа	3	5	7
Хэлэлцсэн асуудлын тоо	тоо	10	24	37
Гүйцэтгэх захирлын хуралд оролцсон байдал	%	100%	100%	100%
ТУЗ-ийн хараат бус гишүүний хуралд оролцсон байдал	%	n/a	100%	100%

ТУЗ-Д ОЛГОСОН УРАМШУУЛАЛ

Төрөл		хэмжих нэгж	2020	2021	2022
Executive / Non-Executive	Нийт хүний тоо	хүн	5	6	6
	Нийт урамшууллын хэмжээ	сая.төг	0	0	3
	Нэг хүнд ногдох дундаж урамшуулал	сая.төг	0	0	0
Independent member	Нийт хүний тоо	хүн	n/a	3	3
	Нийт урамшууллын хэмжээ	сая.төг	n/a	0	3
	Нэг хүнд ногдох дундаж урамшуулал	сая.төг	n/a		
Audit committee member	Нийт хүний тоо	хүн	n/a	3	3
	Нийт урамшууллын хэмжээ	сая.төг	n/a	0	0
	Нэг хүнд ногдох дундаж урамшуулал	сая.төг	n/a	0	0



Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын хүрээнд цөөн, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах зорилгоор дараах заалтуудыг тусгасан байдаг. Үүнд:

- ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилохдоо өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй этгээдийг томилно.
- ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдийн хооронд; том жижиг хувьцаа эзэмшигчдийн хооронд гарч болзошгүй сонирхлын зөрчлийг зөв зохистой, шударга шийдвэрлэх үүрэгтэй ажиллана.
- ТУЗ нь бүх хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудад тэгш мэдээллийг нэгэн зэрэг хүргэнэ.
- ТУЗ нь хөндлөнгийн аудиторын эрх бүхий төлөөлөгчийг хувьцаа эзэмшигчийн хуралд оролцуулах ба хувьцаа эзэмшигчдийг түүнээс асуулт асуух боломж, эрхээр хангана.

АВИЛГА БА ЁС ЗҮЙ



Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?


Компанийн “Ёс зүйн дүрэм”-ийг Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 6 сарын 13-ны өдрийн 19 тоот тогтоолоор, “Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх журам”-ыг Премиум Групп ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 4 сарын 4-ний өдрийн 17 тоот тогтоолоор тус тус баталсан байна.

Компанийн “Ёс зүйн дүрэм”-ийн дагуу дараах ёс зүйн хэм хэмжээг баримтлах бөгөөд зөрчсөн тохиолдолд дараах хариу арга хэмжээг авна.




Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан ашиг сонирхлын зөрчил, авлигаас сэргийлэх чиглэлээр дараах үйлдэл, эс үйлдэл гаргахыг хориглоно. Үүнд:

- Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өөртөө болон нэгдмэл сонирхолтой этгээдэд шууд болон шууд бусаар давуу тал олгох
- Оролцогч этгээдтэй үгсэн тохирох, амлалт өгөх, хээл хахууль авах, бэлэг урамшуулал, шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэх
- Ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөх, сонирхлын зөрчил үүсгэх буюу болзошгүй ажлыг гадуур давхар эрхлэх
- Хувь хүн, албан байгууллагаас зөвшөөрөгдсөн буюу мөнгөн хэлбэрийн бус үүрэг хариуцлага, хүлээлт, найдлага, шаардаагүй, нээлттэй, ердийн байдлаар хаяглагдсанаас бусад бэлэг хүлээн авах



КОМПЛАЙНС



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК болон түүний охин компаниудын дагаж мөрдөх хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудаас баталсан дүрэм, журам, стандартуудыг судалж, дотооддоо хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг зохицуулах удирдамж бүхий “Комплайнсын хяналтын заавар”-ыг ТУЗ-ийн 2022 оны 9 сарын 30-ны өдрийн 32 тоот тогтоолоор баталсан.

Комплайнсын хяналтын заавар нь дараах зорилготой. Үүнд:

- Эрсдэлийн удирдлагыг бий болгох замаар компанийн засаглалыг сайжруулах
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр, дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх
- Компанийн комплайнсын соёлыг бүрдүүлэх, төлөвшүүлэх, сургалт зохион байгуулах
- Зөрчлийн талаар мэдээлэх буюу шүгэл үлээх ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.
- Компани нь дараах стандарт, тусгай зөвшөөрлийг авч холбогдох хууль тогтоомжийн дагуу болон олон улсын сайн жишгийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Төрөл	Нэр	Олгосон он	Хүчинтэй хугацаа	Олгосон байгууллага
Стандарт	Жижиглэн худалдаа газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021:2019 стандарт хангасан Тохирлын гэрчилгээ	2021	2024	Стандарт хэмжил зүйн газар
Стандарт	MNS CAC/RCP 1:2003 Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим			
Стандарт	MNS ISO 22000:2019 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлагын 8-р бүлэг	2023	2026	Монсертф ХХК
Удирдлагын тогтолцоо	Аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо - HACCP			
Тусгай зөвшөөрөл	Архины тусгай зөвшөөрөл	Авснаас хойш 2 жилийн хугацаанд хүчинтэй		Нийслэлийн захирагчийн ажлын алба
	Тамхины тусгай зөвшөөрөл	Авснаас хойш 3 жилийн хугацаанд хүчинтэй		Дүүрэг тус бүрийн хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс

Бүлэг

5

САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Хөдөө аж ахуй ба хүнсний
үйлдвэрлэл
Боловсруулах үйлдвэрлэл

САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ


ХӨДӨӨ АЖ АХУЙ & ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ



Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?

MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь



Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь

БҮЛЭГ 5

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ




Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам



Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь





Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь




ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДАД ОРУУЛЖ БУИ ХУВЬ НЭМЭР

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт бодитой эерэг хувь нэмэр оруулж, хувьцаа эзэмшигчдийнхээ итгэл найдварыг өндөрт хадгалж, салбартаа манлайлж ажиллахыг зорьж байна. Энэ хүрээнд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилтын 9 зорилгод дараах байдлаар хувь нэмрээ оруулж байна (тоон дата мэдээлэл 2023 оны 2 сарын байдлаар).


ТХЗ	Хувь нэмэр
<p>Ядуурлыг устгах</p> 	<p>Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь байгуулагдсан цагаасаа өрхийн гишүүн бүражиллах боломжтой, уян хатан цагийн хуваарь бүхий ажлын байруудыг бий болгож, улмаар орлогын шинэ эх үүсвэртэй болох боломжийг бүх иргэдэд нээлттэй санал болгосоор байгаа. Өрхийн гишүүн бүр орлогын эх үүсвэртэй болох нь ядуурлыг бууруулахад маш чухал үр дүнтэй юм.</p> <p>5 жилийн хугацаанд 10,000 гаруй хүнийг ажлын байраар хангаж Нийт 17,286,720 хүн цагийн ажил бий болгосон Нийт ажилнуудын 52% нь цагийн ажилтан</p>
<p>Эрүүл мэндийг дэмжих</p> 	<p>Үйлчлүүлэгчдийнхээ эрүүл мэндийг хамгаалах зорилгоор 2020 онд олон улсын чанар, хяналтын шаардлагыг хангасан хоолны үйлдвэрийг ашиглалтанд оруулж, НАССР сертификатыг аваад байна. Тус үйлдвэр нь байгуулагдсан цагаасаа хойш нийт 12,461,391 тооны хоолыг үйлдвэрлэн, хэрэглэгчдийн гарт эрүүл, аюулгүй, найдвартай хоолыг өдөр бүр хүргэж байна.</p> <p>Нийт 12,461,391 шинэхэн, эрүүл, аюулгүй хоолыг үйлдвэрлэн нийлүүлсэн.</p> <p>НАССР-ийн сертификатаар баталгаажсан.</p> <p>Түүхий эдээс хэрэглэгчийн гарт хүртэл нийлүүлэлтийн гинжин хэлхээг 100% хянаж байгаа.</p>

<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах</p>  <p>5 ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ</p>	<p>Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Хүйсийн эрх тэгш байдал, нийгмийн тэгш оролцоог хангах чиглэлд онцгой анхаарал хандуулан ажилладаг. Компанийнтөв оффис, түгээлтийн төв, хоолны үйлдвэр болон 300 гаруй салбар дэлгүүрт ажилладаг 3,400 орчим ажилтан, менежерүүдийн 67%-ийг эмэгтэй ажилтнууд бүрдүүлж байна.</p> <p>Дээд шатны удирдлагын 61.5% нь эмэгтэй</p> <p>Дунд шатны удирдлагын 63% нь эмэгтэй</p> <p>Бүх салбар дэлгүүрүүдийн менежерүүдийн 67% нь эмэгтэй</p>
<p>Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах</p>  <p>6 БАТАЛГААТ УНДНЫ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ</p>	<p>Ая тухтай үйлчилгээ үзүүлэх зорилгынхоо хүрээнд СУ сүлжээ дэлгүүрүүдийн 91% нь чанарын шаардлага хангасан ариун цэврийн өрөө, гар угаах тосгуураар тоноглогдсон байдаг бөгөөд үйлчлүүлэгчдэдээ үнэ төлбөргүй үйлчилж байна.</p> <p>Нийт 300 салбарын 91% нь ариун цэврийн өрөө, зориулалтын гар угаах тосгууртай</p>
<p>Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих</p>  <p>8 ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ</p>	<p>СУ сүлжээ дэлгүүрүүд оффис, эмнэлэг, зам дагуу зэрэг хүнсний худалдаа төдийлөн байршдаггүй, хүн амын суурьшлын бус шинэ байршлуудад нийт 201 салбар нээж хүний өдөр тутмын хэрэгцээг хангах дэлгүүр, үйлчилгээг бий болгож байна.</p> <p>201 шинэ үйлчилгээний цэг нээсэн</p> <p>Нийт 122,516,898 бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн гарт хүргэсэн</p> <p>Татварын хууль тогтоомжийг нягт баримталж, нийгмийн даатгалын санд 14'241'886'183.9 төгрөг төвлөрүүлсэн.</p>
<p>Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх</p>  <p>9 ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ</p>	<p>Бид үйлчлүүлэгчдэдээ шинэхэн, эрүүл, аюулгүй хоолыг хүргэх зорилгоор найдвартай хүнсний гинжин хэлхээ, хоол нийлүүлэлтийн сүлжээг бий болгож, салбар бүрт шинэхэн хүнсний хүргэлтийг өдөр бүр хийдэг. Энэхүү дэд бүтцийн тусламжтай дэлгүүрийн өдөр бүрийн хэрэгцээт 2,000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг ердөө 2 хүргэлтээр шийдэж, нийт гарч болох байсан 6,600,000 хүргэлтийг 132,000 болтол бууруулан хотын авто замын хөдөлгөөний ачааллыг буурууллаа.</p> <p>Найдвартай хүнсний гинжин хэлхээ, түгээлтийн сүлжээг бий болгож, 6,600,000 удаагийн тээврийг 132,000 болгож бууруулан хотын замын ачааллыг бууруулсан.</p> <p>Агуулахын бараа ангилалт, ялгалтын DAS/DPS шийдлийг Монголд анх удаа нэвтрүүлж 99%-ийн оновчлолтой захиалгын системийг бий болгосон.</p> <p>SU апп-ын татан авалт 600,000 орчим үүнээс сар бүр идэвхтэй хэрэглэгчид нь 116,000</p>

<p>Тэгш бус байдлыг бууруулах</p> 	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн харилцаанд оролцох тэгш боломжийг бий болгож, найдвартай ажлын байраар хангах нь өөртөө итгэх итгэл, амьдралын идэвхийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Тийм ч учраас бид ХБИ иргэдэд тэгш боломжийг санал болгож, нийт 421,000 хүн цагийн ажлын байр бий болгоод байна.</p> <p>ХБИ ажилтанд 421,000 хүн цагийн ажлын байр бий болгосон.</p>
<p>Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих</p> 	<p>Бид бүх салбар дэлгүүрээр зочилж буй үйлчлүүлэгч бүрийг хүндэтгэн мэндчилж, тэдэнд чин сэтгэлийг найрсаг үйлчилгээг үзүүлэхийг хичээдэг. Энэхүү хичээл зүтгэл маань үйлчлүүлэгч бүрт хотын амьдралын стрессээс ангижирч, шинэ эрч хүчээр өөрийгөө цэнэглэн, улмаар бусдадаа эерэг энерги, эрч хүчийг түгээнэ гэдэгт бид чин сэтгэлээсээ итгэдэг. Тийм ч учраас бид бүх ажилтнууддаа харилцаа, үйлчилгээний соёлын сургалтыг тогтмол явуулдаг бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 224,115 хүн цагийн сургалтыг орж, найрсаг харилцааны дадал зуршлыг ажилтнууддаа хэвшүүлэн ажиллаж байна.</p> <p>Хүн цагийн сургалт: 224,115 хүн цагийн сургалт.</p> <p>CU сүлжээ дэлгүүр нь хурдацтай, далайцтай тэлж УБ хотын гудамж талбайд аюулгүй, гэрэлтэй, харуул хамгаалалттай, гадна, доторхоо бүрэн камержуулсан орчныг бүрдүүлж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд бодитой хувь нэмэр оруулж байна.</p> <p>Дотор болон гадна орчны камерийн хяналт</p> <p>Харуул хамгаалалтын шуурхай үйлчилгээ</p> <p>Мөн хүүхэд багачуудыг аюул ослоос хамгаалах, төөрсөн хүүхдүүийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх зорилготой I CU төслийг Нийслэлийн Цагдаагийн Удирдах Газартай хамтран хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөр нь зөвхөн төөрсөн хүүхдүүдийг хамгаалаад зогсохгүй, гэр бүлийн хүчирхийллээс үүдсэн аюултай нөхцөл байдлын үед хүүхдүүдэд түр орогнох байр болж, аюул өнгөртөл хамгаалах орчныг бүрдүүлж өгдөг.</p> <p>Төөрсөн 7 хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн.</p>
<p>Хариуцлагатай хэрэглээг дэмжих</p> 	<p>Бид үйлчлүүлэгчдэдээ үргэлж ариун цэврийн шаардлага хангасан, шинэ туслах хэрэгсэл, хайрцаг савтай бүтээгдэхүүнээр үйлчилдэг. Улмаар эдгээр туслах хэрэгслийн хаягдал нь байгальд орчинд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор бид түргэн устдаг хуванцар таг, Дэлхийн ойг хамгаалах Rainforest Alliance сертификат бүхий аягыг хамгийн олноор борлуулагддаг кофендоо ашиглаж байна. Мөн Аягагүй кофе хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр 90,415 ширхэг кофены аяга хаягдахаас сэргийлж чадлаа.</p> <p>Кофены аяга болон таг нь 95% байгальд уусдаг бөгөөд улмаар бид 372,000кг хаягдал байгалийг бохирдуулахаас сэргийлээд байна</p>



БОНЗ-ЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ САЙЖРУУЛАХ НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ



Ангилал	Сайжруулах боломжууд
Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоо	<p>MS1: Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн үүрэг, амлалт</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Цаашдын өсөн нэмэгдэж буй дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын санаачилга, чиг хандлага, түүнчлэн шинэ зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлд өгч буй анхаарал зэргийг үндэслэн байгууллагын цаашдын бодлого, стратегид тогтвортой хөгжлийн асуудлуудыг үндсэн асуудлуудыг нэгээр тодорхойлж, холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулж, удирдлагын түвшинд манлайлал үзүүлэн ажиллах. <p>Хамгийн ойрын суралцаж болох жишээ нь:</p> <ul style="list-style-type: none"> "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн үндсэн хувьцаа эзэмшигч болох БНСУ-ын БиЖиЭф Ритэйл Ко., Лтд (BGF Retail Co., Ltd.) компанийн "Байгаль орчны удирдлагын стратеги"-ийг өөрийн үйл ажиллагаанд тохируулан хэрэгжүүлэх БиЖиЭф Ритэйл Ко., Лтд компанийн адил өөрсдийн байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг оролцоонд суурилсан аргаар тодорхойлж, компанийн дунд ба урт хугацааны бодлогод эдгээр асуудлуудыг тусган НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах Тогтвортой хөгжлийн хүрээ (framework)-г боловсруулах, компанийннийт ажилтнуудад уг бодлогын ач холбогдол, цар хүрээ зэргийг таниулах, цаашлаад нийт хувьцаа эзэмшигчид, ханган нийлүүлэгчид, бусад хамтрагч байгууллагууд, харилцагч нарт нээлттэй мэдээллэх <p>MS2.1 & MS2.2: Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> БиЖиЭф Ритэйл Ко., Лтд компанийн адил өөрсдийн байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлуудыг оролцоонд суурилсан аргаар тодорхойлж, компанийн дунд ба урт хугацааны бодлогод эдгээр асуудлуудыг тусган НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулах Тогтвортой хөгжлийн хүрээ (framework)-г боловсруулах, компанийннийт ажилтнуудад уг бодлогын ач холбогдол, цар хүрээ зэргийг таниулах, цаашлаад нийт хувьцаа эзэмшигчид, ханган нийлүүлэгчид, бусад хамтрагч байгууллагууд, харилцагч нарт нээлттэй мэдээллэх <p>MS3.3 & MS3.4: Бүтэц, удирдлага</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Тогтвортой хөгжлийн бодлого, цар хүрээг тодорхойлсон бодлогын баримт бичиг батлагдсанаар бодлогод тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх, зөвлөмжөөр хангах, хянах, дата мэдээлэл цуглуулах, оролцогч талуудыг мэдээллээр хангах, тайлагнах зэрэг үйл ажиллагаа нь цаг, энерги, шинээр суралцах боломж ба нөхцлийг шаарддаг учраас цаашид тогтвортой хөгжил, БОНЗ хариуцсан бүтэн цагийн албан тушаал, ажлын байрыг шинээр үүсгэн, хариуцсан ажилтантай болох Компанид тогтвортой хөгжил, БОНЗ-ын асуудлыг үйл ажиллагааны нэг хэсэг мэт төлөвшүүлэхэд удирдлагын манлайлал чухал нөлөөлөл үзүүлдэг тул цаашид удирдлагын багийн түвшинд тогтвортой хөгжлийн асуудал эрхэлсэн удирдлагын албан тушаалыг шинээр бий болгож байгууллагын манлайлал, үүрэг амлалтыг оролцогч талуудад харуулах.

Ангилал	Сайжруулах боломжууд
Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоо	<p>MS4.1: Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээг уг тайланг бэлтгэх богино хугацаанд цөөн тооны оролцогч талуудаар төлөөлүүлэн гүйцэтгэсэн. Цаашид илүү олон оролцогч талуудаас судалгаа авч нөлөөллийн үнэлгээ (materiality assessment)-г нарийвчлалтай хийж гүйцэтгэх байх шаардлагатай. <p>MS5.1: Чадавч бэхжүүлэх үйл ажиллагаа</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Цаашид тогтвортой хөгжил, БОНЗ-ын бодлого, цар хүрээг тодорхойлж, ТУЗ-өөр батлуулсны дараа нийт ажилтнуудад танилцуулж, сургалтын үеэр тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, тэгш байдал, олон талт байдлын ач холбогдлыг таниулах нь эдгээр бодлого, журмын хэрэгжилт, гүйцэтгэлийг нэмэгдүүлнэ. Шинэ ажилтны сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжил, БОНЗ-ын асуудлуудыг “заавал судлах” байдлаар оруулж занших. “Хэмжиж чадвал – Сайжруулж чадна” дүрмийг байнга санаж, цаашид бүх төрлийн дата мэдээллийг хүйсээр ангилж, бүртгэж, зохистой хадгалж, дүн шинжилгээ хийж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах систем бүрдүүлэх. <p>MS7.2: ОУ-ын стандартын дагуух уур амьсгалын эрсдэл ба тайлагнал</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх. Ингэхдээ компанид шууд болон шууд бус байдлаар учирч болох уур амьсгалын эрсдэлүүдийг тодорхойлох, түүнийг сааруулах болон дасан зохицох стратегийг хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлох. Зорилт тавихын өмнө одоогийн нүүрсхүчлийн давхар ислийн ялгаруулалт (CO2)-ын суурь хэмжээг тооцож, тогтооно. Ингэхдээ өөрийн үйл ажиллагаанаас ялгарч буй CO2 ялгарлыг Score 1, Score 2, Score 3 хүрээнд ангилж тодорхойлно. Цаашид жил бүр уур амьсгалын эрсдэлийн үнэлгээг өмнөх оны болон суурь үзүүлэлттэй харьцуулан ОУ-ын стандартын дагуу хэмжиж, хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж, оролцогч талуудад ил тод тайлагнана. <p>MS8.1: Гишүүнчлэл хамтын ажиллагаа</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Тогтвортой хөгжлийн зорилтуудыг бодитоор хэрэгжүүлэхэд техникийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, чадавч бэхжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд туслалцаа үзүүлдэг маш олон ОУБ байдаг бөгөөд гишүүнээр элсэх, тодорхой зарчмуудыг дагаж мөрдөх үүрэг хүлээснээр компанийндотоод чадавхыг бэхжүүлэх, нэр хүндээ өсгөх, үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа авах олон боломж нээгддэг тул өөрсдийн үйл ажиллагаатай нийцсэн ОУ-ын байгууллага эсвэл санаачилгад нэгдэх, тууштай хамтран ажиллах замаар БОНЗ, тогтвортой байдлын гүйцэтгэлээ сайжруулах.

Ангилал	Сайжруулах боломжууд
Байгаль орчин	<p>E1: Эрчим хүч</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний мэдээллийг бүртгэж, тайлагнаж хянах менежментийн системтэй болох: Ихэнх объектууд бие даасан цахилгааны тоолууртай бөгөөд түрээслэгчээс тоолуур хариуцдаг тохиолдолд эрчим хүчний хэрэглээний мэдээллийг авах зохицуулалт хийснээр тоон мэдээллийг бүртгэх боломжтой. Ингэхдээ компанийн өгөгдөл, мэдээлэл бүртгэлийн системд ЭХ-ний хэрэглээг цахилгаан, дулаан, хөргүүр, шаардлагатай тохиолдолд уурын хэрэглээг тус бүрт нь бүртгэх. • СЭХ-ний эх үүсвэрийг судалж дулаанаа шийдснээр нүүрс, байгалийн хийн хэрэглээг бууруулах: Жишээ нь, дулааны насос, газрын гүний дулаан, нар, салхины эрчим хүч зэрэг. • Дараах зүйлсийг анхаарч "худалдан авалтын журам"-д өөрчлөлт оруулах: • Хөргүүр: Ханган нийлүүлэгчээс суурилуулж буй эсвэл худалдан авалтын хөргүүр болон бусад цахилгаан бараанд цахилгааны хэрэглээ (болон урсгал зардал) бага байх шаардлага тавих, мөн өөрсдийн худалдан авч буй хөргөгч, хөлдөөгч, агааржуулагчийг Energy Star эсвэл эрчим хүч хэмнэлтийн рейтингтэй хувилбарыг сонгох, • ЭХ-ний хэмнэлттэй холбоотой агуулгыг ажилчид, харилцагч нарт ордог сургалтын материалд оруулах. Жишээ нь: ямар үед цахилгаан барааны эрчим хүчний хэрэглээ өсдөг, дуудлагын төвд ирдэг эрчим хүч, цахилгаан бараатай холбоотой түгээмэл асуудлуудыг танилцуулж, зааварчилгааг өгөх. • Нэгдсэн агуулахаас түгээлтийн төврүү хүргэх зарчмыг нэвтрүүлэх: CU-д бараа нийлүүлэгчид өөр өөрийн агуулахаас CU - түгээлтийн төврүү хүргэлт хийдэг бөгөөд жижиг нийлүүлэгчдийн хувьд ашиггүй тээвэрлэх нөхцөлүүд үүсдэг учир байршлаас хамааран жижиг дунд нийлүүлэгчдийн агуулгыг нэг газар байрлахаар шийдэж өгөх боломжтой. • Тээврийн үр ашгийн нэмэгдүүлэх: Түгээлтийн машинд Евро-5 түлш ашиглах, насжилт багатай тээврийн хэрэгсэл сонгох • Ханган нийлүүлэгч үйлдвэрүүдэд эрчим хүчний хэрэглээгээ хэмжиж, тайлагнах, хянах шаардлага тавих. <p>E2: Хүлэмжийн хийн ялгарал</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Хүлэмжийн хийн бүртгэл, тооллогын системтэй болох: Дээрх хүснэгтэд байгаа мэдээлэл болон бусад өөрсдөд чухал мэдээлэл, үзүүлэлтүүдийг тодорхойлж, нэгдсэн байдлаар цуглуулах, бүртгэлжүүлэх, тооцох, хянах төлөвлөгөө гаргах хэрэгтэй. • Дараах зүйлсийг анхаарч "худалдан авалтын журам"-д өөрчлөлт оруулах: • Хөргөлтийн шингэний дулаан барих потенциал: Олон улсад R-410 (гидрофлорокарбон нэгдлийн) хөргөлтийн шингэнийг их хэмжээний хүлэмжийн хий ялгаруулдгаас болоод татгалзаж эхэлсэн учир шинээр худалдан авах агааржуулагч, хөргөгч, хөлдөөгчийг A2L бүлгийн буюу дулаан барих потенциал багатай, эсвэл энгийн нэгдэлт (пропан, аммон гэх мэт) хөргөлтийн шингэн ашигладаг загваруудыг сонгох, тухайн төхөөрөмжийн хөргөлтийн шингэний дулаан барих потенциал (GWP)-ийг анхаарах талаар тусгах хэрэгтэй.

Ангилал	Сайжруулах боломжууд
Байгаль орчин	<p>E3: Уур амьсгалын эрсдэл</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Компанийн уур амьсгалийн өөрчлөлтөд өртөх эрсдэл бүхий асуудлуудыг стресс тест хийж тодорхойлох, Тухайн стресс тестээс гарч ирсэн асуудал, түүнээс урьдчилан сэргийлэх, дасан зохицохтой холбоотой арга хэмжээг өөрийн байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого боловсруулахдаа тусгаж өгөх, Холбогдох асуудал, мэдлэг, мэдээллийг шаардлагатай талуудад мэдээлэх, сургалтын материалд агуулгыг тусгах <p>E4: Ус</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> CU дэлгүүрийн ариун цэврийн өрөөнүүдийн суултуурын усны таталтыг бууруулах технологийн арга хэмжээ авах. <p>E5: Хог хаягдал</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Хоолны үйлдвэрээс гадна Хонхор орчимд хүйтэн хэлхээг түшиглэн байрлах үйлдвэрлэл эрхэлж буй ханган нийлүүлэгчдээс ижил төстэй болон нэгэн төрлийн хог хаягдлууд, тэр дундаа дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой хог хаягдлууд гарч байгааг бүсчилсэн байдлаар менежмент хийж, ложистикийн шийдэл гаргах, хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах. Ингэхдээ Нийслэлтэй хамтарч ажиллах. Хүнсний хаягдлыг ангилж, тусад нь бүртгэдэг болох, Хоолны үйлдвэрт хүнсний хаягдлыг компост хийх байгууламж барих Төлбөрийн баримтны хэвлэлийг багасгах зорилгоор CU аппликейшнээр ибаримтаа авах, эсвэл ибаримт бүртгэгдэх зохицуулалт хийх, Хүнсний үйлдвэрлэгчдийн хадгалалтын хугацааг ашиглах сав баглаа, боодлын технологи нэвтрүүлэх боломжийг судлах, Хог хаягдлыг ангилан бүртгэхээс сэргийлж буй асуудлуудыг шийдэх: Үйлдвэрлэлийн явцад нэг удаагийн хэрэгслийн хаягдлыг хийх битүүмжлэлтэй сав байршуулах. CU салбар дэлгүүрийн хог хаягдлын бүтцийн шинжилгээ хийлгэж, сардаа хэр их хог, хэдэн хувь нь дахин боловсруулах боломжтой гэдэг судалгааг хийлгэх шаардлагатай. CU салбар дэлгүүрүүдийн сүлжээний нөлөөг ашиглан, хоёрдогч түүхий эд худалдан авдаг талуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх. Ингэхдээ шат дараатайгаар, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой маш тодорхой цөөн төрлийн хог хаягдлыг ангилан ялгуулах, олон нийтэд таниулах. Жишээ нь, эхний шатанд үйлчлүүлэгчид хөнгөн цагаан материалаар хийгдсэн ундааны лаазыг ангилж хаях. Түүнийг эдийн засгийн эргэлтэд оруулан ногоон байгууламж босгох гэх мэт. Дараагийн шатанд ус, ундааны савыг хаяхдаа хаягжуулалтын гялгар, тагны хуванцраас салган хаях гэх мэт. <p>E6: Биологийн олон янз байдал</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> Түгээлтийн төв, хоолны үйлдвэрийн газар, талбай, мод тарих талбайтай салбар дэлгүүрүүдэд ногоон байгууламжийг нэмэгдүүлж 30%-д хүргэх. Дэлгүүрийн зөвлөмжид ногоон байгууламжийн эзлэх талбайг зааж өгөх, боломжгүй тохиолдолд дүйцүүлэн өөр газар тариалах шаардлага тавих.

Ангилал	Сайжруулах боломжууд
Нийгэм	<p>S3.1: Эрх тэгш байдал / Жендэрийн бодлого</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Жендэрийн дүн шинжилгээг компанийнхэмжээнд хийж гүйцэтгэн, түүнд үндэслэн цаашдын арга хэмжээг жендэрийн мэдрэмжтэй байдлаар төлөвлөх • Жендэрийн бодлого, журмыг боловсруулж компанийнхэмжээнд мөрдүүлэн ажиллах • Жендэрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх: Компанийнүйл ажиллагаа, бодлого шийдвэр, арга хэмжээний эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөллийг үнэлсний дүнд тухай бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх замаар тухайн үйл ажиллагааны үр өгөөжийг эмэгтэй, эрэгтэй хүмүүст ижил хүртээх, тэгш бус байдлыг таслан зогсоох, нийгмийн хэвшмэл ойлголтыг эвдэхэд хувь нэмэр оруулах. Жендэрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн эцсийн зорилго нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах явдал юм. <p>S3.2: Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого</p> <p>S3.3: Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Одоогийн түвшинд бэлгийн дарамтын эсрэг хариу арга хэмжээ авах байдлыг хөдөлмөрийн гэрээний хүрээнд зохицуулж байгаа хэдий ч үйлчлүүлэгч ажилтанд бэлгийн дарамт болон бусад үг хэлээр, биеээр хүчирхийлэл, доромжлол үзүүлсэн тохиолдолд шүгэл үлээх, хохирогчийг хамгаалах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа нь тодорхой биш байна. • Иймээс, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тусгайлсан бодлого/журамтай болох, ингэснээр эрсдэлийг илүү өргөн хүрээнд тодорхойлж, түүнийг дагалдсан ажилтан, ажил олгогч, гуравдагч этгээдийг эрсдэлээс хамгаалах, гомдлыг аюулгүй хүлээн авах, хохирогчийг хамгаалах арга хэмжээг тодорхойлох боломжтой болно. Мөн бодлогын цар хүрээ, хэрэгжих үйл явцыг нийт ажилтнуудад сургалтаар танилцуулах. • Бүх төрлийн хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалттай холбоотойгоор үйлчлүүлэгчээс болон ажилтнуудаас ирсэн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах шугамтай болох, тэдгээрийг гомдол гаргагчийн эрх ашгийг хамгаалахуйц тохирох албан тушаалтнаар бүртгүүлж, тоог бүртгэх, холбогдох шийдвэр гаргагчдад мэдээлэх, цаашдын бодлогын арга хэмжээ авах тогтолцоо бүрдүүлэх. Хэмжиж чадвал анхааралдаа авна, арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. <p>S3.4: Ажилтнуудын хүйсийн харьцаа</p> <p>S3.5: Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа</p> <p>S3.6: Гүйцэтгэх удирдлагын багийн хүйсийн харьцаа</p> <p>S3.7: Дунд болон анхан шатны нэгжийн хүйсийн харьцаа</p> <p>S3.8: Жендэрт суурилсан цалингийн зөрүү</p>

Ангилал	Сайжруулах боломжууд
Нийгэм	<p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Шийдвэр гаргах буюу удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийг төлөөллийг 40 хувиас багагүй байхаар тодорхойлох • Менежер, дэлгүүрийн менежер албан тушаал дахь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалингийн зөрүүг багасгах, цаашид ижил тэгш цалин хөлс олгодог байх • Жендэрийн бодлого батлагдсаны дараа нийт ажилтнуудад жендэрийн эрх тэгш байдлын талаар сургалт зохион байгуулах, энэ чиглэлд чадавх бэхжүүлэх ажлууддыг дотооддоо өрнүүлэх • Компанийнжендэрийн эрх тэгш байдлыг хангах, хүртээмжтэй, олон талт байдлыг бий болгох чиглэлд авч хэрэгжүүлж арга хэмжээний талаар нийт ханган нийлүүлэгч, оролцогч талуудад нээлттэй танилцуулж, мөн ижил шаардлагыг тавьж ажиллах • Хамтран ажиллагч түнш байгууллагууд, ханган нийлүүлэгчдийн мэдээллийг цаашид хүйсээр ангилан бүртгэж байх. Ингэснээр цаашид жендэрийн мэдрэмжтэй шийдвэр гаргах суурь нөхцөл бүрдэнэ. • Компани нь Жендэрийн бодлогоо баталсны үндсэн дээр нийгэмд нөлөөлөхүйц олон нийтийн арга хэмжээ, мэдэгдэл хийх, аливаа уулзалт арга хэмжээнд компанийнжендэрийн эрх тэгш байдлын төлөөх үүрэг амлалтын талаар мэдээлж, салбарын бусад оролцогчдыг уриалж, үлгэрлэх, цаашлаад энэ чиглэлт төсөл, хөтөлбөр, санаачилгыг өөрийн нөөц боломжийн хүрээнд дэмжиж хамтарч ажиллах. <p>S5.1: Оролцогч талууд, олон нийтийн оролцоо</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Цаашид оролцогч талуудаа бүлэгт ангилан тодорхойлох, оролцогч тал тус бүрт компанийн үйл ажиллагааны үзүүлэх нөлөөллийг тодорхойлсны үндсэн дээр оролцогч талуудын эрх ашигийг хөндөхгүй хамтран ажиллах тухай "Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах" тусгайлсан бодлого, журам эсвэл хөтөлбөртэй болж компанийн дээд удирдлагаар батлуулах, батлагдсан бодлогын баримт бичгийн талаар нийт оролцогч талуудад тэгш мэдээлэл хүргэж ажиллах. <p>S5.2: Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Цаашид "Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого"-н хүрээнд БОНЗ-ын нөлөөллийн үнэлгээг хийлгэж, түүнд үндэслэсэн нийгмийн нөлөөллийн бодлого боловсруулах, дээд удирдлагаар батлуулах. <p>S5.6: Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none"> • Цаашид Нийгмийн хариуцлагын хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг ТХЗ-д оруулж буй хувь нэмрээр ангилан бүртгэх, нийт орлого ба зардалд эзлэх хувийг тооцоолж, тайлан мэдээлэлд тусгаж занших.

Ангилал	Сайжруулах боломжууд
Засаглал	<p>G1.1: Компанийн засаглалын бодлого, журам G3.1: Комплайнсын бодлого, журам</p> <p>Сайжруулах зөвлөмж:</p> <ul style="list-style-type: none">• Компанийн засаглал, комплайнсыг хэрэгжүүлэх хөтөлбөр, хяналтын заавар байгаа хэдий ч тусгайлсан "Компанийн засаглалын бодлого", "Комплайнсын бодлого" байхгүй байна. Цаашид эдгээр бодлогыг боловсруулж ажиллах.
Салбарын нэмэлт	

